



ХҮНИЙ ЭРХЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ЦАГ

Олон Улсын Санхүүгийн
Корпорацийн хүний эрхийг
ухамсартайгаар хүндэтгэн
сахих үүрэг



ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

АГУУЛГА

1. Удиртгал
2. Эмнести Интернэшнлийн үнэлгээ
3. ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт ба хүний эрх
4. Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн хувилбар
 - 4.1 ОУСК үүрэг хариуцлагаас зайлсхийсэн нь
 - 4.2 Хүний эрхийг хүндэтгэн сахих талаар үйлчлүүлэгчдэд тавигдах шаардлага
 - 4.3 Хүйсийн тэгш байдал
 - 4.4 Хэл найруулгын өөрчлөлт
5. ОУСК-ийн нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлого дахь хүний эрхийг ухамсартайгаар сахих зарчим
 - 5.1 Хүний эрхийн үр нөлөөний урьдчилсан үнэлгээ
 - 5.2 Үйлчлүүлэгчийн мэдээллийг бие даан шинжлэх, биелэлтийг хөндлөнгөөс хянах
 - 5.3 ОУСК-ийн зүгээс нутгийн иргэдийг татан оролцуулах
6. Гүйцэтгэлийн 1-р стандарт: үйлчлүүлэгчид тавигдах шаардлага
 - 6.1 Хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих зарчим зайлшгүй шаардлагатай болох нь
 - 6.2 Гуравдагч талын үйл ажиллагаанаас үүдсэн эрсдэл
 - 6.3 Чанартай тулгуур тоо баримт
 - 6.4 Хавсарсан үр нөлөө
 - 6.5 Өргөдөл гомдол шийдвэрлэх журам
7. Гүйцэтгэлийн 3, 4, 5, 7-р стандартын шинэчилсэн хувилбар
 - 7.1 Гүйцэтгэлийн 3-р стандарт
 - 7.2 Гүйцэтгэлийн 4-р стандарт
 - 7.3 Гүйцэтгэлийн 5-р стандарт
 - 7.4 Гүйцэтгэлийн 7-р стандарт

1. УДИРТГАЛ

Эмнести Интернэшнл байгууллага 2010 оны 5-р сарын 1-нд Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) Нийгэм ба Хүрээлэн буй орчны тогтвортой байдлын бодлого, Гүйцэтгэлийн стандарт ба холбогдох удирдамж, ОУСК-ийн Нээлттэй байдлын бодлого зэргийг багтаасан 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ хэмээх баримт бичигт санал зөвлөмж өгсөн юм. Энэ санал зөвлөмжиндөө Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийг хүний эрхийн үзэл санааны үүднээс эргэн харах, ОУСК-ийн бодлого, үйл ажиллагааны хэм хэмжээнд хүний эрхийг зохих ёсоор тусгах зэрэг асуудлыг багтаасан.¹

2010 оны 6-р сарын 2-нд ОУСК Тогтвортой байдлын цар хүрээний шинэчилсэн хувилбарын төслийг танилцуулсан бөгөөд уг баримт бичиг нь “хүний эрхийн асуудалд цаашид илүү тодорхой ач холбогдол өгч, бэхжүүлэхэд” чиглэсэн.² Түүнчлэн, ОУСК Тогтвортой байдлын цар хүрээг хүний эрхийн хэд хэдэн баримт бичигтэй харьцуулсан дүн шинжилгээ хийсэн билээ.³

Эмнести Интернэшнл дээрх баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, ОУСК-ийн Нийгэм ба Хүрээлэн буй орчны тогтвортой байдлын бодлого, Гүйцэтгэлийн шинэ стандартыг ОУСК-ийн дэмжлэгтэй төслүүд болон бизнесийн үйл ажиллагаанд авч хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хүндэтгэн хэрхэн сахиж байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон юм.

¹ Amnesty International Submission to the Review of the International Finance Corporation (IFC) Sustainability Framework, May 2010, AI Index: IOR 80/003/2010. Amnesty International's comments on the 2006 Sustainability Framework should be read in conjunction with comments provided on the revised text in this document.

² Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт ба Нэмэлт протоколууд.

³ IFC, The International Bill of Human Rights and IFC Policies and Performance Standards (2010).

2. ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ҮНЭЛГЭЭ

ОУСК-аас 2006 онд гаргасан Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт Эмнести Интернэшнлээс 2010 оны 5-р сард өгсөн санал зөвлөмжийн дийлэнх хувийг өнөөг хүртэл анхаарч үзээгүй байгаа учраас уг баримт бичгийн шинэчилсэн төсөлд өгөх санал зөвлөмж ерөнхийдөө өөрчлөгдөөгүй. Үүнд:

- ОУСК-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигтээ тус байгууллага хүний эрхийн зөрчилд шууд хүргэж байгаа буюу түүнд нэмэр болж байгаа аливаа үйл ажиллагааг дэмжихгүй гэдгээ тодорхой илэрхийлэх нь зүйтэй. Энэхүү бодлогоо тодорхойлохдоо ОУСК санхүүгийн байгууллагын хувьд хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих үүрэг хүлээхийн хамт өөрийн үйлчлүүлэгч байгууллагуудаас НҮБ-ын ЕНБД-ын Бизнес ба Хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч Проф.Жон Руггийн өгсөн зөвлөмжид нийцүүлэн хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахихыг шаардах ёстой.
- Гүйцэтгэлийн стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдсон тогтолцоо болон хувь хүмүүс хийгээд орон нутагт үйлчлүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүдийн үзүүлж буй үр нөлөөнд тавьж буй хяналтын үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авах нь чухал. Ялангуяа, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд төслийн үр нөлөөний талаарх ноцтой мэдээллийг хүлээн авах, үнэлж дүгнэх ОУСК-ийн тогтолцоо, холбогдох орон нутаг болон ард иргэдтэй хамтран ажиллах явдал болон өнөөгийн хяналтын механизм зэргийг эргэн харах шаардлагатай.
- Үр нөлөөний үнэлгээ болон нийгэм, хүрээлэн буй орчны удирдлагын үйл явцын тухай Гүйцэтгэлийн 1-р стандартыг хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих зарчимд тулгуурлах, түүний дотор ОУСК-ийн дэмжлэгийг хүртсэн төслүүдийн хүний эрхийн үр нөлөөний үнэлгээг багтаах шаардлагад нийцүүлэн өөрчлөх ёстой.
- Гүйцэтгэлийн 2-8-р стандартыг хүний эрхийн холбогдох хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.

Илүү дэлгэрэнгүй зөвлөмжийг 5, 6, 7-р хэсэгт тусгалаа.

3. ОУСК-ИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН СТАНДАРТ БА ХҮНИЙ ЭРХ

ОУСК 2010 оны 6-р сарын 2-нд тус байгууллагын бодлого олон улсын хүний эрхийн гэрээ конвенциуд болон бусад баримт бичигтэй хэрхэн нийцэж байгаа талаар харьцуулсан дүн шинжилгээ хийсэн юм.⁴ Тухайлбал, ОУСК-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийг Бизнес ба Хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн 2008 оны тайлан, Олон улсын хүний эрхийн билль,⁵ “шинээр батлагдсан холбогдох олон улсын конвенци, тунхаглал”,⁶ Хүний эрхийн эрх зүйн Кастан төвөөс гаргасан бизнесийн лавлах, Данийн Хүний эрхийн хүрээлэнгээс гаргасан үнэлгээний аргачлал зэрэг баримт бичигт тусгагдсан шалгуурт үндэслэн үнэлэлт дүгнэлт хийжээ. Уг дүн шинжилгээг Олон улсын хүний эрхийн билльд тусгагдсан хүний эрхүүд хийгээд Гүйцэтгэлийн стандарт хоёрын хэлхээ холбоог харуулах үүднээс нэг матрикст товчлон багтаасан.

*Эдийн засаг, нийгэм, соёлын хүрээн дэх хүний эрхийн олон талт байдал Гүйцэтгэлийн стандартад сайн тусгагдсан (хөдөлмөрийн эрх, эрүүл мэнд/бохирдлоос сэргийлэх, албадан нүүлгэн шилжүүлэлт, соёлын өв) бөгөөд уг стандарт нь ОУСК-ийн үйл ажиллагаанд хамаарах иргэний болон улс төрийн эрхийг мөн тусгасан байна (орон нутгийн оролцоо, хамгаалалтын ажилтнууд, гомдол гаргах журам, уугуул иргэд, эмзэг бүлгийнхэн г.м).*⁷

Эмнести Интернэшнл Нийгэм ба Хүрээлэн буй орчны тогтвортой байдлын (НХОТБ)бодлого болон Гүйцэтгэлийн Стандартад хүний эрхийн асуудал хэрхэн тусгагдсан талаар үнэлгээ хийх шаардлагатай байгааг ОУСК хүлээн зөвшөөрөхийн сацуу бизнесийн байгууллагуудын хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрч байгааг талархан хүлээн авч байна. ОУСК-ийн дэмжлэгтэй төслүүд болон Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлт зэрэг нь хүний эрхийн олон салбарт нөлөө үзүүлж болзошгүй учраас энэ удаагийн дүн шинжилгээ нь цагаа олсон төдийгүй нэн чухал зүйл мөн.

Хэдий тийм боловч, ОУСК-аас гаргасан матрикст Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийг шинэчлэн гаргахдаа зайлшгүй тусгах ёстой байсан хүний эрхийн тулгамдсан асуудлын талаар хангалттай дүн шинжилгээ хийгээгүй байна. Олон тохиолдолд хийсэн дүн шинжилгээ нь өнгөцхөн бөгөөд гол асуудлын мөн чанарыг гүн гүнзгий гаргаж чадаагүй байна. Түүчлэн, уг матриксаас НХОТБ-ын бодлого хийгээд Гүйцэтгэлийн стандартад хүний эрхийг тусгах талаар ОУСК-ийн гаргасан дүгнэлтийг хангалттай гаргаж чадсангүй. ЭИ хэдийгээр ОУСК Бизнес ба Хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгчийн бодлогыг өөрийн үйл ажиллагаагаар дэмжих үүрэг амлалт авсан⁸ ч Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих үйл явц огт тусгагдаагүйг ОУСК-ийн дүн шинжилгээнд тодорхойлоогүйд харамсаж байна.

⁴ IFC, The International Bill of Human Rights and IFC Policies and Performance Standards (2010).

⁵ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт ба Нэмэлт протоколууд.

⁶ For the UN Human Rights Council, John Ruggie, Report of the Special Representative of the Secretary-General on the issue of human rights and transnational corporations and other business enterprises, Protect, Respect and Remedy: a Framework for Business and Human Rights: April 2008, A/HRC/8/5.

⁷ IFC, The International Bill of Human Rights and IFC Policies and Performance Standards (2010), p 2.

⁸ Report of the Special Representative of the Secretary-General on the issue of human rights and transnational corporations and other business enterprises, Business and Human Rights: Further steps towards the operationalization of the “Protect, Respect and Remedy” Framework, A/HRC/14/27, 9 April 2010.

БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛААРХИ ТУСГАЙ ИЛТГЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙГАА НЬ

2010 оны 4-р сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай илтгэгч бизнесийн байгууллагуудын хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хариуцлага нь “ямар ч нөхцөлд бүх компани хүний эрхийг хүндэтгэн сахих түгээмэл үүрэг хариуцлага оногдуулж байгаа хэрэг мөн” хэмээн мэдэгдсэн.⁹ Энэхүү үүрэг хариуцлага нь компаниудын зүгээс түүнийг биелүүлэх, түүний дотор хүний эрхийг ухамсартайгаар хэрэгжүүлэхийн тулд тодорхой үйл ажиллагаа явуулах шаардлага тавьдаг. Бизнесийн байгууллага хүний эрхийг ухамсартайгаар хэрэгжүүлэх үзэл баримтлал нь аливаа компани хүний эрхэд сөргөөр нөлөөлөх зүйлсийг тодорхойлох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга хэмжээ авахыг шаарддаг. Бизнес ба Хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар бизнесийн байгууллагын хүний эрхийг ухамсартайгаар хэрэгжүүлэх үзэл баримтлал дараахи 4 хэсгээс бүрдэнэ:

- *Тухайн байгууллагын хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг амлалтаа багтаасан бодлогын баримт бичиг*
- *Хүний эрхэд нөлөөж байгаа болон нөлөөж болзошгүй компаний үйл ажиллагаа, харилцааны талаархи тогтмол үнэлгээ*
- *Дээрх үүрэг амлалт болон үнэлгээг дотоод хяналтын тогтолцоонд тусган оруулах*
- *Гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнаж байх*¹⁰

Бизнес ба Хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хариуцлага бол тасралтгүй үргэлжлэх, динамик зүйл бөгөөд хүний эрхийн эрсдлийг даван туулахад бизнесийн үйл ажиллагаанд өртөж байгаа орон нутгийн байгууллага, иргэдийг татан оролцуулах, тэдэнтэй харилцан ярилцах шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэсэн.

Түүнчлэн тэрээр хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахихын гол зорилго бол компаниуд хүний эрхийг хүндэтгэж, үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч байгаагаа харуулах боломж олгох явдал гэдгийг онцолсон.

Хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих дээр дурдсан 4 гол бүрэлдэхүүн хэсэг Тогтвортой байдлын цар хүрээнд тусгагдаагүй байна. Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт ОУКС ба түүний үйлчлүүлэгчдийн алинд ч тухайн байгууллага болоод үйлчлүүлэгч компани хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг амлалтаа тусгасан бодлоготой байх шаардлага тавиагүй байна. Мөн НХОТБ бодлого болон Гүйцэтгэлийн Стандартад ОУКС ба түүний үйлчлүүлэгчдийн алинд ч хүний эрхийн үр нөлөөний асуудлаар үнэлгээ хийх үүрэг хүлээлгээгүй. ОУСК-ийн дүн шинжилгээнд “бизнесийн байгууллагууд, иргэний нийгэм болон бусад оролцогч талууд хүний эрхэд учрах дийлэнх эрсдлийг нийгэм, хүрээлэн буй орчны асуудалд илүү анхаарал хандуулах замаар үр дүнтэй шийдвэрлэж болно гэдгийг ойлгож байна”¹¹ хэмээн дурджээ. Энэ нь Бизнес ба Хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгчийн бизнес ба хүний эрхийн үүрэг хариуцлагын тухай дүн шинжилгээнд хүний эрхийн үр нөлөөг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн хэм хэмжээнд үндэслэн зохих ёсоор үнэлж болно гэж дурдсантай

⁹ *Business and Human Rights: Further steps towards the operationalization of the “Protect, Respect and Remedy” Framework*, A/HRC/14/27, 9 April 2010, para 65.

¹⁰ *Business and Human Rights: Further Steps Toward the Operationalization of the “Protect, Respect and Remedy” Framework*, A/HRC/14/27, 9 April 2010, paras 83-84.

¹¹ IFC, *The International Bill of Human Rights and IFC Policies and Performance Standards* (2010), p2.

зөрчилдөж байгаа юм.¹² Эмнести Интернэшнл 2010 оны 5-р сард гаргасан 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт хийсэн дүн шинжилгээндээ уг үзэл санааг дэмжиж, хүний эрхийн үр нөлөөний талаар тодорхой үнэлгээ хийх шаардлага байгааг чухалчилсан хэд хэдэн тодорхой жишээг дурдсан болно.¹³

Эцэст нь, Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт ОУКС ба түүний үйлчлүүлэгчдийн алинд ч өөрсдийн хяналт, мэдээлэл, тайлангийн тогтолцоонд хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг амлалт, үнэлгээг багтааж байх талаар ямар ч үүрэг хүлээлгээгүй байна. Хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих 4 гол бүрэлдэхүүн хэсгийг орхигдуулснаараа ОУКС-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичиг нь тус байгууллагаас Бизнес ба Хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгчийн бодлогыг өөрийн үйл ажиллагаагаар дэмжих талаар авсан үүрэг амлалтыг тусгаж чадаагүй нь харагдаж байна.

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЦАР ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН ТУЛГУУР ГЭРЭЭ КОНВЕНЦИУДАЙ ХАРЬЦУУЛАН ҮНЭЛЖ ЧАДСАНГҮЙ

ОУСК-ийн хийсэн дүн шинжилгээ нь зөвхөн Хүний эрхийн олон улсын билльд гол анхаарлаа чиглүүлсэн бөгөөд хүний эрхийн өргөн хүрээтэй үүрэг хариуцлагыг багтаасан олон улсын хүний эрхийн бусад хэм хэмжээг харгалзан үзээгүй байна. Хэдийгээр харьцуулсан матриксийн өмнөх үгэнд ОУСК Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийг “шинээр батлагдсан холбогдох олон улсын гэрээ конвенци, тунхаглалуудтай” харьцуулан үзсэн гэж дурдсан боловч тэдгээрийг тодорхой дурдаагүй төдийгүй НХОТБ бодлого болон Гүйцэтгэлийн Стандартад тэдгээрийг хэрхэн тусгасан талаар ямар нэг үнэлэлт хийгээгүй байна. Хамгийн гол нь Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглал болон НҮБ-ын тулгуур конвенциуд зэрэг ОУСК-ийн Хүний эрхэд хөрөнгө оруулах цаг төслүүд болон бизнесийн үйл ажиллагаанд шууд холбогдох баримт бичгийн талаар огт дурдсангүй.

ОУСК хүйсийн тэгш байдлын асуудал тулгамдсан асуудал гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч хийсэн дүн шинжилгээндээ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг дурдсангүй.

Мөн ОУСК-ийн дүн шинжилгээ хүний эрхийн асуудалд хяналт тавьж, удирдамж өгөх үүрэгтэй НҮБ-ын хүний эрхийн байгууллагуудын шинжээчид болон тэдгээрээс гаргасан шийдвэрүүдийг тусгаагүй байна. Хэрэв эдгээр байгууллагаас гаргасан удирдамж, чиглэлийг Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт тусгаж өгсөн бол уг баримт бичиг олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж чадах байв.

НАРИЙВЧИЛСАН БУС ХАРЬЦУУЛАЛТ

Харьцуулсан матрикс нь хүний эрхийн асуудалд нэлээд ерөнхий бөгөөд хийсвэр маягаар хандсанаас гадна Гүйцэтгэлийн стандартад ОУ-ын Хүний эрхийн билльд заасан хэм хэмжээг хэрхэн тусгасан талаар шаардлагатай мэдээллийг багтаагаагүй

¹² Protect, Respect and Remedy: a Framework for Business and Human Rights, A/HRC/85, 7 April 2008, para 61

¹³ Amnesty International Submission to the Review of the International Finance Corporation (IFC) Sustainability Framework, May 2010 (Index: IOR 80/003/2010).

байна. Ялангуяа, уг матрикс хүний эрхийн агуулгыг тодорхойлж чадаагүйгээс гадна НХОТБ бодлого болон Гүйцэтгэлийн Стандартыг тэрхүү агуулгын хүрээнд үнэлж чадаагүй байна. Тухайлбал, ОУСК эрүү шүүлт, харгис, хүний ёсноос гадуур буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг тодорхойлж, уг эрх Гүйцэтгэлийн 2, 4-р стандартад зохих ёсоор тусгагдсан байна хэмээн үнэлжээ.¹⁴ Гэсэн хэдий боловч, эрүү шүүлт, харгис, хүний ёсноос гадуур буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх нь олон арга замаар, түүний дотор хүчээр нүүлгэн шилжүүлэх замаар зөрчигдөж болох юм.¹⁵ Тиймээс хүний эрхийн дүн шинжилгээ нь ОУСК-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн Гүйцэтгэлийн 5-р стандарт хүчээр нүүлгэн шилжүүлэх асуудлыг тусгаагүй талаар авч үзэх шаардлагатай юм. Чухамдаа Гүйцэтгэлийн 5-р стандартад үйлчлүүлэгч компаниудыг хүчээр нүүлгэн шилжүүлэх ажилд оролцохыг хориглосон заалт байхгүй байгаа нь уг Гүйцэтгэлийн стандарт бүхэлдээ хүний эрхийн хэм хэмжээг зохих ёсоор тусгасан баримт бичиг гэж хэлэхэд ихээхэн хүндрэл учруулж байна.

Түүнчлэн хүний эрхийн асуудлыг ОУСК-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигтэй харьцуулсан матрикст эргэлзээтэй асуудал олон байна. Тухайлбал, уг матрикс амьжиргааны зохих төвшингөөр хангагдах эрх (түүний дотор орон байр, хоол хүнс, ус, эрүүл ахуйн үйлчилгээгээр хангагдах) Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт хэрхэн тусгагдсан талаар авч үзээд “уг эрхийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсэг олон тооны Гүйцэтгэлийн стандартад, тодруулбал 1, 2, 3, 4, 5, 6, 7-р стандартад тусгалаа олжээ”¹⁶ хэмээн дүгнэсэн байна. Хэдийгээр эдгээр стандарт нь амьжиргааны зохих төвшингөөр хангагдах эрхийн зарим нэг талыг тусгасан боловч түүний салшгүй хэсэг болох цэвэр ус, орон байраар хангагдах эрхийг хэрэгжүүлэхийн тулд авах ёстой чухал арга хэмжээний талаар юу ч дурдаагүй байна.

Ерөнхийдөө ОУСК-ийн үнэлгээ нь орон байр, цэвэр ус зэрэг асуудал хийгээд хүний эрхийн агуулга зэргийг хольж хутгасан байна. Учир нь усны асуудлаарх төслийн боломжит үр нөлөөг дурдах нь цэвэр усаар хангагдах эрхтэй холбоотой төсөл, үйл ажиллагааны үр нөлөөг задлан шинжлэхтэй адил зүйл биш. Үр нөлөөг үнэлэхийн тулд юуны түрүүнд цэвэр усаар хангагдах эрхэд чухам юу багтахыг нарийвчлан авч үзэх ёстой бөгөөд ингэж чадахгүй бол чухал асуудлууд орхигдоход хүрнэ.

¹⁴ IFC, The International Bill of Human Rights and IFC Policies and Performance Standards (2010), 7.

¹⁵ НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Хуучин Югославт цыганчуудыг гэр орноос нь албадан нүүлгэж, орон байрыг шатаасан нь уг конвенцийг зөрчсөн харгис, хүмүүнлэг бус, хүний нэр төрийг гутаан доромжилсон үйлдэл болохыг тогтоосон. Communication No161/2000: Yugoslavia, submitted by Hajrizi Dzemailj. Document CAT/C/29/D/161/2000.

¹⁶ IFC, The International Bill of Human Rights and IFC Policies and Performance Standards (2010), 18-19. ОУСК-ийн үзэж байгаагаар Гүйцэтгэлийн 1-р стандартад усны эх үүсвэрийг оролцуулаад эрсдэл, үр нөлөөг тооцоолсон, Гүйцэтгэлийн 2-р стандартад ажилчдын орон байр, эрүүл ахуйн үйлчилгээ, түүний дотор усан хангамжийн чанар, менежментийн талаар үйлчлүүлэгчдийн хүлээх үүргийг тусгасан, Гүйцэтгэлийн 3-р стандартад төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдлоос зайлсхийх буюу багасгах зэрэг хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөний эсрэг арга хэмжээний талаар тусгасан, Гүйцэтгэлийн 4-р стандартад байгалийн нөөц баялгийг ашигласнаас үүдэн нутгийн иргэдэд учрах сөрөг нөлөөнөөс зайлсхийх үүргийг үйлчлүүлэгчдэд хүлээлгэсэн, Гүйцэтгэлийн 6-р стандартад нүүлгэн шилжүүлсэн иргэдийн амьжиргааны төвшинг сайжруулах, сэргээх талаар тодорхой шаардлагуудыг тусгасан, Гүйцэтгэлийн 7-р стандартад уугуул иргэдийн амьжиргаанд төслийн зүгээс үзүүлэх сөрөг нөлөөнөөс зайлсхийх, түүнийг бууруулах үүргийг үйлчлүүлэгчдэд хүлээлгэсэн.

Ялангуяа, Гүйцэтгэлийн стандартуудын аль нь ч хүний эрхийг хүндэтгэн сахихын тулд ямар шаардлага тавигдах ёстой, ямар баталгаа хэрэгтэй талаар нарийвчлан заагаагүй байна.¹⁷ Эдгээр шаардлага, баталгааг Гүйцэтгэлийн стандартад нарийвчлан тусгах ёстой.

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫНЦАР ХҮРЭЭ БАРИМТ БИЧИГТ ОРХИГДУУЛСАН ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛУУД

Зарим тохиолдолд НХБО-ны бодлого ба Гүйцэтгэлийн стандартад огт тусгагдаагүй буюу өнгөц дурдагдсан хүний эрхийн асуудлыг бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа мэтээр матрикст харуулжээ. Жишээ нь, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхийг НХБОТБ-ын бодлогод “гомдол гаргах үр дүнтэй механизмын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн” бөгөөд Гүйцэтгэлийн 1-р стандартад гомдол гаргах механизмд тавигдах ерөнхий шаардлагыг, Гүйцэтгэлийн 1, 2, 4, 5, 7-р стандартад илүү нарийвчилсан шаардлагыг тус тус тодорхойлох замаар тусгасан гэж ОУСК-ийн дүн шинжилгээнд дурджээ. Хэдийгээр гомдол гаргах механизм нь болзошгүй асуудлыг шийдвэрлэх чухал арга хэрэгсэл мөн боловч ихэнхи тохиолдолд зөрчигдсөн эрхийг үр дүнтэйгээр сэргээн тогтоох хангалттай арга хэрэгсэл болж чаддаггүй.

Олон улсын эрх зүй ёсоор эрх зүйн хамгаалалт авах эрхийн тухай “эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах” хэмээн заасан байдаг.¹⁸ Энэхүү эрхэд гуравдагч талууд, ялангуяа компаниуд халдах тохиолдол байдаг. Тухайлбал, Нигерийн гурвалжинд компаниуд газрын тос алдагдсан шалтгаан, орон нутгийн иргэдэд түүний үзүүлэх үр нөлөөний талаарх нэн чухал мэдээллийг шүүх болон орон нутгийн иргэдээс нуун дарагдуулж байсан зэрэг эрх зүйн хамгаалалт авах эрхийг хөсөрдүүлж байсан тохиолдлыг Эмнести Интернэншнл бүртгэсэн байдаг.¹⁹ Эмнести Интернэншнлийн бүртгэсэн өөр бусад тохиолдолд компаниуд шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлж, тэднээс болж хохирсон орон нутгийн иргэдийн эрх зүйн хамгаалалт авах эрхийг зөрчиж байсан нь илэрсэн.²⁰ Эрх зүйн хамгаалалт авах эрхэд компаниуд нөлөөлөх чадавхтай байдгийг эс харгалзан Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт ОУСК хийгээд түүний үйлчлүүлэгчдэд уг эрхийг хүндэтгэн сахих үүрэг хүлээлгээгүй байна.

¹⁷ Цэвэр усаар хангагдах эрхийн хувьд тэдгээр баталгаа нь: (a) эрх ашиг нь хөндөгдөж байгаа ард иргэдтэй зохих ёсоор зөвлөлдөх, (b) авах арга хэмжээний талаар цаг тухайд нь, бүрэн дүүрэн мэдээлэл өгөх, (c) явагдах үйл ажиллагааны талаар хангалттай хугацааны өмнө урьдчилан мэдэгдэх, (d) эрх ашиг нь хөндөгдөж байгаа ард иргэдэд шүүхэд хандах боломж олгох, (e) шүүхэд хандахад нь эрх зүйн туслалцаа үзүүлэх зэрэг болно. Энэ талаар дараах баримт бичгийг үзнэ үү: Committee on Economic, Social and Cultural Rights, General Comment No.15 (2002), The right to water (Articles 11 and 12 of the International Covenant on Economic, Social and Cultural Rights), E/C.12/2002/11, 20 January 2003, p 17, para 56. Албадан нүүлгэлтээс сэргийлэхэд тавигдах шаардлагын талаар дараах баримт бичгийг үзнэ үү: Committee on Economic, Social and Cultural Rights General Comment No. 7, The right to adequate housing (Article 11(1) of the Covenant): forced evictions, para 15. See also Basic Principles and Guidelines on Development-Based Evictions And Displacement, Annex 1 of the report A/HRC/4/18 of the Special Rapporteur on adequate housing as a component of the right to an adequate standard of living, considered by the Human Rights Council in 2007.

¹⁸ International Covenant on Civil and Political Rights, Article 2(3).

¹⁹ See Amnesty International, *Petroleum, pollution and poverty in the Niger Delta*, (Index: AFR 44/017/2009) June 2009.

²⁰ Тухайлбал, Папуа Шинэ Гвинейд ВНР компанийн түлхээсээр Ок Теди уурхайтай холбоотой нөхөн төлбөрийн талаар өргөдөл гомдлыг хүлээж авахгүй байх тухай хууль батлагдаж байв.

НИЙГЭМ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОДЛОГОД ХИЙСЭН ДУТУУ ДУЛИМАГ ДҮН ШИНЖИЛГЭЭ

НХБОТХ-ийн бодлого ОУСК-ийн хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих үүрэг амлалтыг багтаасан. Хэдийгээр шинэчилсэн НХБОТХ-ийн бодлогод ОУСК хувийн хэвшлийн салбарын хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөх болсныг дурдсан²¹ боловч ОУСК-ийн зүгээс хүний эрхийг хэрхэн хүндэтгэн сахих байгаа талаар дурдсангүй. ОУСК хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрөөгүй байгаа нь НХБОТХ-ийн бодлого учир дутагдалтай болохыг харуулж байна.

Тиймээс ч ОУСК-ийн дүн шинжилгээнд НХБОТХ-ийн бодлогын талаар тун цөөхөн дурдсан нь гайхах зүйл биш юм. ОУСК-ийн гаргасан дүн шинжилгээнд харьцуулсан матрикт дурдсан 35 төрлийн хүний эрхээс ердөө 8 нь НХБОТХ-ийн бодлогод тусгагдсан²² бөгөөд тэдгээрээс хэд хэд нь зөвхөн НХБОТХ-ийн бодлогын дагуу ОУСК-ийн үйлчлүүлэгчид гуравдагч талын үйлдсэн хүний эрхийн зөрчилд хамсаатан болох эрсдлээ тодорхойлох ёстой гэсэн агуулгаар л дурдагдсан байна. ОУСК-ийн дүн шинжилгээнд НХБОТХ-ийн бодлогын талаар ийнхүү хангалтгүй дурдсан нь уг бодлого ОУСК-ийн үйл ажиллагаагаа явуулахдаа хүний эрхийг хүндэтгэн сахих баталгаа болж чадахгүй байгааг харуулж байгаа юм.

ХАНГАЛТГҮЙ ДҮГНЭЛТ

ОУСК “эдийн засаг, нийгэм, соёлын салбар дахь хүний эрхийн өргөн цар хүрээ Гүйцэтгэлийн стандартад хангалттай сайн тусгагдсан” бөгөөд “ОУСК-ийн үйл ажиллагаатай холбоотой иргэний болон улс төрийн салбар дахь хүний эрхийн асуудлыг хамруулсан” хэмээн дүгнэжээ. Харин Эмнести Интернэшнл одоогийн Гүйцэтгэлийн стандарт нь түүний эцэслэн хянасан хувилбарт зайлшгүй багтаах ёстой хүний эрхийн болзошгүй үр нөлөөний зөвхөн нэг хэсгийг тусгасан гэж үзэж байна.

Эмнести Интернэшнл 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичиг болон энэхүү баримт бичигт хийсэн дүн шинжилгээндээ хэд хэдэн чухал асуудлыг тодорхойлсон. Тухайлбал, Гүйцэтгэлийн стандарт орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, хоол хүнс, ус, орон байраар хангагдах эрхэд хүрээлэн буй орчны бохирдол хэрхэн нөлөөлж байгаа болон ямар арга хэмжээ авах талаар зохих ёсоор тодорхойлж чадсангүй. Түүнчлэн, уг стандарт ОУСК болон түүний үйлчлүүлэгчдийн аливаа үйл ажиллагаа иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэх үр дагаварт хүргэхгүй байх талаар ямар нэг үүрэг хүлээлгээгүй. Цаашлаад уг стандартадуугуул иргэдийн эрхтэй холбоотой олон улсын хүний эрхийн хэм хэмжээг тусгаагүй байна. Эдгээрээс болон матрикт тусгалгүй орхисон зүйлсээс харахад Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт иргэний, улс төрийн, эдийн засгийн болон соёлын эрхийн асуудал “сайн тусгагдсан” хэмээх ОУСК-ийн дүгнэлт үнэмшихэд бэрх байна.

²¹ IFC, Policy on Social and Environmental Sustainability, Rev-0.1, 14 April 2010, p 31, para 10.

²² Хуулийн этгээд байх эрх, хуулийн өмнө эрх тэгш байх эрх, хуулиар эрхээ эрх тэгш хамгаалуулах, ялгаварлан гадуурхахгүй байх эрх, шүүхээр зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрх, эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхээс ангид байх, хүүхдийн эрх, гэрлэх, мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх.

4. ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЦАР ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН ШИНЭЧИЛСЭН ХУВИЛБАР

Дэлхийн Банкны Хөгжлийн Үр ашгийг нэмэгдүүлэх асуудлаарх тайланг (хойшид “CODE тайлан” гэх),²³ хянан үзэж, шинэчлэн найруулахдаа ОУСК хүний эрхийн асуудал бол онц тулгамдсан асуудал гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Ийнхүү хүний эрхийн асуудал ОУСК-ийн үйл ажиллагаанд хамаатай болохыг хүлээн зөвшөөрсөн нь анхны чухал том алхам юм. Гэхдээ зөвхөн үүгээр сэтгэл ханаж болохгүй. ОУСК-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт ОУСК-ийн аливаа төсөл, үйл ажиллагаа хүний эрхийн зөрчлийн шалтгаан буюу хувь нэмэр болох ёсгүй гэдгийг тодорхой тусгах шаардлагатай. Ийм зорилт нь ОУСК-ийн эрхэм зорилго хийгээд гишүүн орнуудын хүлээсэн үүрэг, компаниудын хүний эрхийг хүндэтгэх хариуцлагад нийцнэ.

Бизнес ба хүний эрхийн асуудлаархи Тусгай төлөөлөгч “хүний эрхийг хүндэтгэх явдал бол бүх компаниудын ямар ч тохиолдолд биелүүлэх ёстой тулгуур үүрэг”²⁴ хэмээн мэдэгдсэн. Түүний ажилд хариу болгож Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлого (НБОТББ)-ын шинэчилсэн хувилбарт “хувийн хэвшил” хүний эрхийн үүрэг хариуцлага хүлээх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрсөн.²⁵ Гэхдээ ОУСК ийнхүү зөвхөн хувийн хэвшилд ийм үүргийг оногдуулж байгаа нь хангалтгүй ойлголт юм. Бизнес ба хүний эрхийн асуудлаархи Тусгай төлөөлөгч өөрийн тайландаа зөвхөн хувийн хэвшил төдийгүй бүх бизнесийн байгууллагын үүрэг хариуцлагын талаар дурдсан. Төрийн байгууллагууд тэрчлэн төр ба хувийн холимог хэвшлийн бизнесийн байгууллагууд ч хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хүлээх учиртай. Түүний нэгэн адил ОУСК олон улсын санхүүгийн байгууллага болохынхоо хувьд өөрийн үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэн сахих ёстой.

Мөн гишүүн орнууд нь хүний эрхийг хүндэтгэн сахиж, хамгаалах, түүний дотор хүний эрхийг гуравдагч тал зөрчихөөс хамгаалах үүрэг хүлээсэнзасгийн газар хоорондын байгууллага болохын хувьд ОУСК-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичиг тус байгууллага хүний эрхийн хүндэтгэн сахих, хөхиүлэн дэмжих талаар идэвхитэй үүрэг гүйцэтгэх ёстой болохыг тодорхой тусгах шаардлагатай юм. Энэ нь ОУСК-ийн эрхэм зорилгод ч нийцнэ. ОУСК-ийн дүрэмд тус корпорацийн зорилго бол “эдийн засгийн хөгжлийг урагшлуулах явдал”²⁶ хэмээн заасан бөгөөд ОУСК-ийн эрхэм зорилгыг тодорхойлсон мэдэгдэлдээ эдийн засгийн хөгжлийг урагшлуулах нь “ядуурлыг бууруулж, хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх зорилготой”²⁷ хэмээн заасан байдаг. Хүний эрхийг бүхий л талаар хүндэтгэн сахих нь ядууралд нэрвэгдсэн хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх гол түлхүүр билээ. Тиймээс ч Эмнести Интернэшнл дараахи зөвлөмжийг өгч байна. Үүнд:

²³ IFC, *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, 14 April 2010, available at [http://www.ifc.org/ifcext/policyreview.nsf/AttachmentsByTitle/Phase2_CODEReport/\\$FILE/Compounded+CODE_Progress+Report+on+IFC%27s+Sustainability+Framework_Review+and+Update.pdf](http://www.ifc.org/ifcext/policyreview.nsf/AttachmentsByTitle/Phase2_CODEReport/$FILE/Compounded+CODE_Progress+Report+on+IFC%27s+Sustainability+Framework_Review+and+Update.pdf), last accessed 19 July 2010.

²⁴ Protect, Respect and Remedy: a Framework for Business and Human Rights, A/HRC/85, 7 April 2008, para 24.

²⁵ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 31, para 10

²⁶ IFC, *Article I, Articles of Agreement*, available at http://www.ifc.org/ifcext/about.nsf/Content/Article_I, last accessed 19 July 2010.

²⁷ IFC, *Mission Statement*, available at

<http://www.ifc.org/ifcext/about.nsf/7afae2a79a656e70ca25692100069831/d0e9906f064f418185256d03006fcfaa?OpenDocument>, last accessed 19 July 2010.

1. ОУСК НХБОТБ-ын бодлогодоо хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг амлалтаа тодорхой илэрхийлсэн хүний эрхийн бодлогыг оруулж өгөх хэрэгтэй бөгөөд ингэснээр ОУСК өөрийн үйлчлүүлэгчдийг тус байгууллагын дэмжлэгтэй бизнесийн аливаа үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэн сахих бүхий л арга хэмжээг авах үүрэг амлалт авч байгаа юм.
2. Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн дагуу хүний эрхийг хүндэтгэн сахихад тавигдах шаардлагууд хийгээд тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар үйлчлүүлэгчдэд ойлгомжтой байлгах үүднээс Гүйцэтгэлийн стандартад хүний эрхийн асуудлыг тусгайлан тодорхой тусгах.
3. Баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахдаа үйлчлүүлэгчид хүйсийн ялгавартай эрсдлүүд болон бизнесийн үйл ажиллагааны үр нөлөөнд анхаарал хандуулах шаардлагатайг тодорхой илэрхийлсэн заалт оруулах
4. Орон нутгийн иргэд болон бусад оролцогчдын талаархи заалтыг тодруулах. Үүнд “орон нутгийн иргэд болон бусад оролцогчдын оролцоо” гэсэн өгүүлбэр хэрэглэж болох юм.
5. Аливаа оролцогчдын үйл ажиллагаанд тухайн орон нутгийн хүний эрхийг хамгаалах асуудал нэн тэргүүнд тавигдах ёстойг тодорхой болгох.
6. Гүйцэтгэлийн стандартад тусгагдсан үйл ажиллагааны олон төлөвлөгөөний уялдаа холбоог илүү тодорхой болгох.

4.1. ОУСК ҮҮРЭГ ХАРИУЦЛАГААС ЗАЙЛСХИЙСЭН НЬ

Шинэчилсэн баримт бичигт хүний эрхийн асуудлаар ОУСК тодорхой үүрэг амлалт аваагүй төдийгүй тус байгууллагын дэмжлэгтэй төсөл, үйл ажиллагаанаас үүдсэн хүний эрхийн үр нөлөөний талаар аливаа хариуцлага хүлээхээс зайлсхийсэн агуулгатай болжээ. Тодруулбал, Гүйцэтгэлийн стандарт ОУСК-д нэгэн адил хамаарна гэсэн заалтыг хассанаар уг стандарт зөвхөн ОУСК-ийн үйлчлүүлэгчдэд хамаарахаар болжээ.²⁸ Оруулсан бусад өөрчлөлтөөс харахад эрсдлийг ОУСК биш түүний үйлчлүүлэгчид хүлээх ёстой болсон байна.²⁹

ОУСК-аас гаргасан CODE тайланд “тус байгууллагын санхүүжүүлж буй бизнесийн үйл ажиллагаа хүний эрхийн сөрөг эрсдэл дагуулж болзошгүй эсэхийг тодорхойлж, түүнээс зайлсхийх буюу шийдвэрлэхэд анхаарч байна”³⁰ гэж дурдсан. ОУСК НХБОТБ-ын бодлогодоо хүний эрхийг хамгаалах талаар хүлээсэн хамгийн чухал үүрэг амлалт бол “хүний эрхийн ноцтой зөрчлийн хамсаатан болох эрсдлээс сэргийлэхийн тулд

²⁸ НХБОТБ-ын хуучин эхийн 4-рт (2006 оны 4-р сарын 30-нд батлагдсан) “Гүйцэтгэлийн стандарт нь ОУСК болоод түүний үйлчлүүлэгчдэд нийгмийн ба хүрээлэн буй орчны үйл ажиллагаагаа үр дүнд суурилсан хандлагаар хэрэгжүүлэх, сайжруулахад тус дөхөм болох үндсэн баримт бичиг мөн” гэж заасан байв. Шинэчилсэн хувилбарт “болоод түүний” гэсэн үгийг хассан бөгөөд “Гүйцэтгэлийн стандарт нь ОУСК-ийн үйлчлүүлэгчдэд нийгмийн ба хүрээлэн буй орчны үйл ажиллагаагаа эрсдэл ба үр дүнд суурилсан хандлагаар хэрэгжүүлэх, сайжруулахад тус дөхөм болох үндсэн баримт бичиг мөн” гэж нарийулсан байна. See Para 5, Policy on Social and Environmental Sustainability, Rev-0.1, 14 April 2010, p 29.

²⁹ For example, paragraph 6 of the revised Policy on Social and Environmental Sustainability inserts the following words (in italics): “By adhering to this Policy, IFC seeks to [...] (ii) help clients manage their social and environmental risks and impacts; (iii) improve their performance; and (iv) enhance positive development outcomes on the ground.” (emphasis added), p 30.

³⁰ IFC, *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, p 24, 14 April 2010, available at [http://www.ifc.org/ifcext/policyreview.nsf/AttachmentsByTitle/Phase2_CODEReport/\\$FILE/Compounded+CODE_Progress+Report+on+IFC%27s+Sustainability+Framework_Review+and+Update.pdf](http://www.ifc.org/ifcext/policyreview.nsf/AttachmentsByTitle/Phase2_CODEReport/$FILE/Compounded+CODE_Progress+Report+on+IFC%27s+Sustainability+Framework_Review+and+Update.pdf), last accessed 19 July 2010.

ОУСК уг бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээ зогсооход хүрч болно”³¹ гэж заасан явдал юм. Гэвч ОУСК тийм үйл ажиллагааг санхүүжүүлэхээ зогсоох ёстой гэж үүрэг хүлээсэн байдлаар биш харин ийнхүү “зогсооход хүрч болно” хэмээн идэвхигүй хэлбэрээр илэрхийлсэн нь зүйд огт нийцэхгүй байна. Түүнээс гадна “хүний эрхийн ноцтой зөрчил” гэсэн нь ОУСК хүний эрхийн бусад зөрчилд хүргэх эрсдэлтэй бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ гэж ойлгоход хүрэгж байна. Тиймээс ОУСК Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн хувилбарт дор хаяж тус байгууллагын төслүүд болон бусад үйл ажиллагаа хүний эрхийн зөрчилд хүргэх буюу тус нэмэр болох ёсгүй гэсэн заалт оруулах ёстой.

ОУСК Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн хувилбарт тусгагдсан шаардлагууд олон улсын хүний эрхийн эрх зүйд хэрхэн нийцэж байгаа талаар дурдалгүй орхигдуулсан тохиолдол нэлээд байна. Тухайлбал, НХБОТБ-ын бодлогод зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой заалтаа зөвхөн үндэсний хууль тогтоомжийг дурдсан байна. Тодруулбал, ОУСК-ийн зөвлөх үйлчилгээнд “хувийн хэвшилд зориулсан нийгэм, хүрээлэн буй орчны стандартыг боловсруулах” ажил багтана³² гэжээ. ОУСК хувийн хэвшил хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг атлаа хувийн хэвшилд хөгжлийн стандарт боловсруулж өгөх асуудлыг багтаадаг зөвлөх үйлчилгээндээ олон улсын хүний эрхийн хэм хэмжээг тусгаагүй байгаа нь зүйд нийцэхгүй юм.

Тэрчлэн, НХБОТБ-ын бодлогын шинэчилсэн хувилбарын 13-р хэсэгт ОУСК-ийн хүлээсэн үүрэг амлалтын талаар шинэ бичвэр нэмж оруулсан ч хүний эрхийн талаар огт дурдаагүй байна. Тухайлбал, уг бичвэрт ОУСК “тогтвортой байдлын гүйцэтгэл”, “тогтвортой өсөлт”, “тогтвортой үнэт зүйлс” зэргийг дээшлүүлэхтэй холбоотой бизнесийн үйл ажиллагаандаа нийгэм, хүрээлэн буй орчны үр дүнг анхаардаг биенесийн түншүүдтэй хамтран ажиллах тухай дурджээ.³³ Бизнесийн байгууллагуудын хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хариуцлагын хүрээнд ОУСК тэдэнтэй хамтран ажиллахдаа явуулж буй бүхий л үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэн сахихад нь тус дөхөм үзүүлэх үүрэг хүлээх ёстой.

4.2. ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН САХИХ ТАЛААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хэдийгээр ОУСК өөрийн үйлчлүүлэгчдийг хүний эрх зөрчигдөх эрсдлийг тодорхойлох, түүнээс зайлсхийх буюу шийдвэрлэх үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт үйлчлүүлэгчдийн зүгээс хүний эрхийг хүндэтгэн сахих үүргээ биелүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох талаар дорвитой алхам хийгээгүй байна. Түүний оронд “бизнесийн байгууллагууд, иргэний нийгэм болон бусад оролцогчид бизнесийн хүрээн дэх нийгэм, хүрээлэн буй орчны асуудлууд нь хүний эрхийн асуудлуудтай ерөнхийдөө эн тэнцүү гэдгийг ойлгож байна”³⁴ гэж дүгнэжээ. Тиймээс ч, ОУСК Гүйцэтгэлийн стандартад нийгэм, хүрээлэн буй орчны асуудалд гол анхаарал хандуулахын зэрэгцээ хүний эрхийн асуудалд шаардлагатай

³¹ IFC, Para 19, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 33.

³² IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 39, para 39.

³³ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 31, para 13.

³⁴ IFC, *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, p 24, 14 April 2010.

үед” анхаарал хандуулж байхыг санал болгосон.³⁵

ОУСК-ийн санал болгож буй энэ хандлагад хоёр гол дутагдал байна. Юуны түрүүнд, бизнесийн байгууллагууд, иргэний нийгэм болон бусад оролцогчид бизнесийн хүрээн дэх нийгэм, хүрээлэн буй орчны асуудлууд нь хүний эрхийн асуудлуудтай “ерөнхийдөө эн тэнцүү” гэж ойлгох нь буруу юм. Хэдийгээр хүрээлэн буй орчин, нийгэм, хүний эрхийн үр нөлөөнд үнэлэлт дүгнэлт өгөх үйл явц өөр хоорондоо холбоотой байж болох ч нийгэм, хүрээлэн буй орчны үнэлгээ нь хүний эрхэд учирч болзошгүй сөрөг үр дагаврыг үр дүнтэй тодорхойлох хангалттай арга хэрэгсэл болж чадахгүй. НҮБ-ын ЕНБД-ын Тусгай илтгэгчийн тодорхойлсноор “хүний эрхийн үр нөлөөний үнэлгээ нь эрсдлийн үнэлгээ, хүрээлэн буй орчин, нийгмийн үр нөлөөний үнэлгээ зэрэгтэй холбогдож болох ч заавал олон улсын хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн хэм хэмжээнд тулгуурлах ёстой”.³⁶ Нийгэм, хүрээлэн буй орчны үнэлгээ нь хүний эрхийн үр нөлөөг эргэцүүлэх хангалттай арга хэрэгсэл болж чадахгүй талаар Эмнести Интернэшнлээс ОУСК-ийн 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт өгсөн санал зөвлөмжид онцлон дурдсан.

Хоёрдугаарт, ОУСК хүний эрхийн асуудалд “шаардлагатай үед” анхаарал хандуулж байхыг санал болгосон хэдий ч Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн хувилбарт ОУСК ба түүний үйлчлүүлэгчдэд хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг хүлээлгэсэн тодорхой заалт бараг алга байна. Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн анхны хувилбарт ч ОУСК-ийн үйлчлүүлэгчдэд хүний эрхийн асуудлаар тавигдах шаардлагын талаар дурдсан зүйл хомс байсан. НХБОТБ-ын бодлогод хувийн хэвшил хүний эрхийг хүндэтгэн сахих нь зүйтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн ерөнхий мэдэгдлээс³⁷ өөр зүйл байхгүй бөгөөд ОУСК өөрийн үйлчлүүлэгчдийг гуравдагч талын үйлдсэн хүний эрхийн зөрчлийн хамсаатан болох эрсдлээ тодорхойлж байхыг хүссэн.³⁸ Гэхдээ энэ нь ОУСК-аас үйлчлүүлэгчдэдээ тавьдаг шаардлагыг багтаасан Гүйцэтгэлийн стандартад хангалттай тусгагдаагүй. Уг Гүйцэтгэлийн стандартын 1-8-р заалтад хүний эрхтэй холбоотой 3 зүйл дурдагджээ.

Гүйцэтгэлийн стандартын шинэчилсэн хувилбарт хүний эрхтэй холбоотой ганц чухал зүйл байгаа нь ишлэл хэсэгт дурдагдсан байна. 6-р зүйлд хэрэгжүүлэх төслийнхөө нийгэм, хүрээлэн буй орчинд учрах эрсдэл, үр нөлөөг тодорхойлох үүргийг үйлчлүүлэгчид хүлээлгэжээ.³⁹ Ишлэл хэсэгт хүний эрхэд “томоохон хэмжээний” эрсдэл, үр нөлөө гарч болзошгүй тохиолдолд уг үнэлгээнд хүний эрхийн асуудлыг багтааж болно гэж заасан. Энэхүү ишлэл хэлбэр, агуулгын хувьд ОУСК-ийн үйлчлүүлэгчид

³⁵ IFC, *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, p 24, 14 April 2010.

³⁶ *Protect, Respect and Remedy: a Framework for Business and Human Rights*, A/HRC/85, 7 April 2008, para 61.

³⁷ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 31, para 10.

³⁸ “ОУСК үйлчлүүлэгчид нь эдгээр эрсдлийг хүний эрхийг ухамсартайгаар сахих зарчимд үндэслэн, орон нутгийн онцлогт тохируулан, гуравдагч талын үйл ажиллагаанд үзүүлэх өөрийн нөлөө буюу хяналт болон тэрхүү үйл ажиллагаанаас олох үр ашигээргийг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхойлно гэж найдаж байна. ОУСК хүний эрхийг ухамсартайгаар сахих зарчимд тулгуурлан үйлчлүүлэгчдийн тодорхойлсон тэдгээр эрсдлийг хянан үзэх бөгөөд тэдгээр эрсдлийг шийдвэрлэх боломж байгаа эсэх, хэрэв шийдвэрлэх боломжтой бол ямар нөхцөл шаардлагатай зэргийг тодорхойлно. Хүний эрхийн ноцтой зөрчлийн хамсаатан болох зэрэг зарим эрсдлийн хувьд ОУСК тухайн бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс татгалзах шаардлагатай болж болох юм.” : *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 39, para 19.

³⁹ 7-р ишлэлд “Анхаарал хандуулж, тодорхойлох ёстой эрсдэл, үр нөлөөнд уур амьсгалын өөрчлөлт, хүний эрүүл мэнд, хүний эрх, хүйсийн ялгаатай байдал, экосистемийн үйл ажиллагаа, усны эх үүсвэрийн олдоц зэрэгтэй холбоотой эрсдэл багтана” гэж заасан. See IFC, *Performance Standard 1, Rev-0.1, Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, p45, 14 April 2010..

тэдний явуулж буй үйл ажиллагааны хүний эрхэд учруулж болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлох, үнэлэх, түүнээс зайлсхийх буюу шийдвэрлэх аливаа үүрэг хүлээлгэхэд хангалттай бус байна. Хэлбэрийн хувьд авч үзэхэд ийм чухал асуудлыг ишлэлд оруулсан нь ОУСК төсөл, үйл ажиллагаандаа хүний эрхийн асуудлыг авч үзэлгүй орхигдуулдаг бөгөөд тэдгээр төсөл, үйл ажиллагаа нь хүний эрхэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэдэгт ач холбогдол өгөөгүй болохыг харуулж байна. Түүнчлэн уг ишлэлд хүний эрхийн асуудлыг ойлгох, шийдвэрлэхийн тулд үйлчлүүлэгчид ямар арга хэмжээ авах талаар хангалттай тодорхойлж чадаагүй. Үйлчлүүлэгчид хүний эрхийн болзошгүй сөрөг үр дагаврыг явцын дунд өөрсдөө тодорхойлох хэрэгтэй гэж дурдсанаас өөр хүний эрхийн “томоохон хэмжээний” эрсдэл байгааг хэрхэн үнэлэх нь ойлгомжгүй байна. Гүйцэтгэлийн 1-р стандартад хүний эрхэд учирж болзошгүй эрсдэл хийгээд тэрхүү эрсдлийг үнэлэх үйл явцын аль алиныг ойлгомжтой тусгах шаардлагатай юм.

ОУСК-ийн Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт хүний эрхийн асуудлыг тодорхой тусгасан хамгийн том ахиц бол орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой Гүйцэтгэлийн 4-р стандарт юм. Уг стандарт ёсоор ОУСК-ийн үйлчлүүлэгчид өөрсдийн үндсэн ажилчид ба гэрээт гүйцэтгэгчдийн аюулгүй байдлыг хангахын тулд олон улсын хүний эрхийн зарчмууд болоод хүмүүнлэгийн эрх зүйг удирдлага болгох үүрэг хүлээхээр болсон.⁴⁰ Хэдий тийм боловч уг стандартад олон улсын хүний эрхийн эдгээр зарчим чухам ямар баримт бичигт тусгалаа олсон байдгийг тодорхой заагаагүйгээс гадна үйлчлүүлэгчдээс тэдгээрийг дагаж мөрдөх шаардлага тавиагүй, зөвхөн “удирдлагаболгох ёстой” гэсэн нь хангалтгүй юм. Гүйцэтгэлийн 4-р стандартад ОУСК-ийн дэмжлэгтэй төслүүд дээр хувь хүний аюулгүй байдлыг хангахдаа НҮБ-аас баталсан Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм, Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын зүгээс хүч болон галт зэвсэг хэрэглэх тухай НҮБ-ын Үндсэн зарчмууд, Аюулгүй байдал ба хүний эрхийн тухай сайн дурын зарчмууд⁴¹ зэргийг үйлчлүүлэгчдийн зүгээс дагаж мөрдөх талаар тодорхой заалт тусгах учиртай. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хүрээнд ОУСК болон түүний үйлчлүүлэгчид олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах хүчний зүгээс дээрх зарчмуудыг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх үүднээс тухайн улсын засгийн газартай зөвшилцөх ёстой гэсэн заалт оруулах нь зүйтэй.

Хүний эрхтэй холбоотой хамгийн сүүлчийн заалт Гүйцэтгэлийн 7-р стандартад тусгагдсан байгаа бөгөөд уугуул иргэдтэй харилцах харилцаанд хамаарч байна.⁴² Гэхдээ уг стандартын агуулга нь уугуул иргэдийн олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг бүрэн дүүрэн тусгаагүй ба тодорхой тохиолдолд уугуул иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр өгсөн зөвшөөрлийг авах тухай зохих ёсоор дурдаагүй байна. Харин түүний оронд Тогтвортой байдлын цар хүрээ баримт

⁴⁰ IFC, Para 12, Performance Standard 4, Community Health, Safety, and Security, Rev-0.1, p 70.

⁴¹ Code of Conduct for Law Enforcement Officials, Adopted by General Assembly resolution 34/169 of 17 December 1979, <http://www2.ohchr.org/english/law/codeofconduct.htm>, last accessed 20 July 2010; Basic Principles on the Use of Force and Firearms by Law Enforcement Officials, Adopted by the Eighth United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders, Havana, Cuba, 27 August to 7 September 1990, <http://www2.ohchr.org/english/law/firearms.htm>, last accessed 20 July 2010; Voluntary Principles on Security and Human Rights, <http://www.voluntaryprinciples.org/>, last accessed 20 July 2010.

⁴² ОУСК-ийн Гүйцэтгэлийн 7-р стандартын шинэчилсэн хувилбарын нэг зорилго нь “Хөгжлийн үйл явц уугуул иргэдийн хүний эрх, нэр төр, хүсэл эрмэлзлэл, соёл, байгалийн баялагт суурилсан амьжиргаа зэргийг бүх талаар хүндэтгэн сахих явдлыг бэхжүүлэхэд чиглэнэ.” See IFC, Performance Standard 7, Indigenous Peoples, Rev-0.1, p 87.

бичигт чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр зөвлөлдөх гэсэн илүү зөөлөн шаардлагыг оруулжээ. ОУСК CODE тайландаа чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр зөвлөлдөх гэдэг нь чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр өгсөн зөвшөөрлийг авах гэдэгтэй “зарчмын хувьд эн тэнцүү” гэж үзсэн учраас олон улсын эрх зүйд нийцсэн нэр томъёог ашиглахаа хойшлуулсан гэж дурдсан.⁴³ Энэхүү хандлага ямар учир дутагдалтай болох талаар 7-р хэсэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

4.3. ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДАЛ

Хүйсийн эрх тэгш байдлын асуудал ОУСК-ийн зөвлөлдөх үйл явцын эхний үе шатанд уур амьсгалын өөрчлөлт, экосистем болон хүний эрхийн асуудалтай эн зэрэгцэн хэлэлцэгдсэн чухал асуудлын нэг юм.⁴⁴ ОУСК Гүйцэтгэлийн стандартаа “хүйсийн тэгш байдлын шаардлагыг бэхжүүлэх” өнцгөөс харж, дүн шинжилгээ хийсэн бөгөөд анхаарах хэд хэдэн салбарыг тодорхойлжээ.⁴⁵ ОУСК “хуулийн өмнө тэгш эрхтэй байхыг хөхиүлэн дэмжиж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаараа дамжуулан тэгш боломжийг бий болгож, хөгжиж байгаа орнуудын эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ашиглагдаагүй нөөц боломжийг өргөжүүлэхэд хүн бүр дуу хоолойгоо нэгтгэх боломжийг хангах замаар ...эмэгтэйчүүдэд шинэ боломж бололцоо бий болгоход” хүчин чармайлт гаргахаа илэрхийлсэн.⁴⁶ Тийм ч учраас, ОУСК “хүйсийн тэгш байдалд мэдрэмжтэй хандахын”⁴⁷ чухлыг НХБОТБ-ын бодлого болон Гүйцэтгэлийн стандартад тусгайлан зааж өгсөн.⁴⁸

Хүйсийн ялгавартай сөрөг үр нөлөөнд анхаарал хандуулах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрсөн нь эерэг зүйл боловч Гүйцэтгэлийн стандартын шинэчилсэн бичвэрт ОУСК-ийн үйлчлүүлэгчдэд хүйсийн тэгш байдлын асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх талаар хангалттай удирдамж өгч чадаагүй байна. Жишээ нь, Гүйцэтгэлийн 1-р стандарт (ишлэлд дурдсан) тухайн төслийн нийгэм, хүрээлэн буй орчны болзошгүй эрсдэл, үр нөлөөг тодорхойлохдоо үйлчлүүлэгчид “хүйсийн ялгаатай байдал”-тай холбоотой асуудлыг анхаарахыг зөвлөмж болгожээ.⁴⁹ Тэрчлэн, “ядуу болон эмзэг байдлаас шалтгаалж тухайн төсөл шууд буюу ялгавартайгаар, хэт тэнцвэргүйгээр нөлөөлж байгаа бүлэг буюу нутгийн иргэдийг тодорхойлох” шаардлага үйлчлүүлэгчдэдээ тавихын хамт хүйсийн тэгш байдал гэх мэт хүчин зүйлийг харгалзан үзэхийг анхааруулсан (мөн ишлэлд дурдсан)⁵⁰ байна.

⁴³ IFC, *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, 14 April 2010, p.11. IFC has indicated that this issue will be further considered in August, with Board consideration occurring in October 2010: IFC Consultation, Brussels, 12 July 2010.

⁴⁴ *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information. Annex A. Review and Update of IFC's Sustainability Framework: Overview of Key Issues*, IFC, April 14 2010, p. 19.

⁴⁵ *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information* p. 10, para 32.

⁴⁶ *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information* p 22 para c.

⁴⁷ *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information* p. 23, para c.

⁴⁸ The revised Policy on Social and Environmental Sustainability now contains an explicit statement that the IFC “expects its clients to minimize gender-related project risks and unintended gender differentiated impacts” and a commitment to “creating opportunities for women both through its financing activities as well as AS [Advisory Services]”: IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2020, p 31, para 11.

⁴⁹ IFC, *Performance Standard 1, Rev-0.1, Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April, 2010, p. 45, para 6, footnote 7.

⁵⁰ IFC, *Performance Standard 1, Rev-0.1, Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April, 2010, p. 47 para 11.

Гүйцэтгэлийн стандартын шинэчилсэн хувилбарт үйлчлүүлэгчид зөвлөлдөх үйл явцдаа эмэгтэйчүүдийг татан оролцуулах хэрэгтэй болохыг мөн дурсдан.⁵¹ Гэвч Гүйцэтгэлийн 1-р стандартад үйлчлүүлэгчид хүйсийн ялгавартай үр нөлөөг хэрхэн үнэлэх, шийдвэрлэх, төсөл хэрэгжих явцад эмэгтэйчүүдтэй хэрхэн үр дүнтэй зөвлөлдөх талаар дэлгэрэнгүй заасан зүйл огт алга байна.

Хэдийгээр Зааварчилгаанд үйлчлүүлэгчдэд зориулсан зарим нэг нэмэлт мэдээлэл байгаа боловч амьдрал дээр үйлчлүүлэгчид хүйсийн ялгавартай үр нөлөөнд хэрхэн анхаарал хандуулах талаар тодорхой ойлголт өгч чадахааргүй юм. Түүнээс гадна тэдгээр мэдээлэл нь эмэгтэйчүүдийн хүний эрхийн асуудал болон эмэгтэйчүүд, охидын эрхийг бүрэн дүүрэн хамгаалахын тулд авах шаардлагатай арга хэмжээний талаар ямар ч эх сурвалж дурдаагүй байна. ОУСК өөрийн НХБТБ-ын бодлого болон Гүйцэтгэлийн стандартад хүний эрхийн холбогдох гэрээ конвенци, хэм хэмжээг илүү тодорхой оруулснаар хүйсийн тэгш байдлын асуудлаархи хүчин чармайлтдаа илүү ахиц гаргах болно. Нэмэлт мэдээллийг 7-р хэсэгт оруулав.

4.4. ХЭЛ НАЙРУУЛГЫН ӨӨРЧЛӨЛТ

Шинэчлэн найруулсан бичвэрт орсон 3 өөрчлөлтийг тайлбарлах шаардлагатай байна. Эхнийх нь “орон нутгийн иргэд” гэсэн нэр томъёоноос татгалзаж “оролцогчид” гэсэн нэр томъёо хэрэглэх болсон явдал юм. Хоёр дахь нь “хамгийн бага байлгах” гэсэн үгийг “багасгах” хэмээн өөрчилсөн явдал бөгөөд харин гурав дахь нь шинэчилсэн бичвэрийн дагуу шаардлагагүй болсон үйл ажиллагааны төлөвлөгөөг байнга дурдсаар байгаа явдал юм.

“ОРОН НУТГИЙН ИРГЭД” БА “ОРОЛЦОГЧИД”

ОУСК-ийн үзэж байгаагаар Гүйцэтгэлийн 1-р стандартад хийгдсэн хамгийн чухал өөрчлөлтийн нэг бол зөвхөн төслийн нөлөөнд өртсөн иргэд төдийгүй бүх оролцогчидтой янз бүрийн хэмжээгээр харилцахын тулд үйлчлүүлэгчдээс орон нутгийн иргэдтэй илүү ойр дөт хамтран ажиллах шаардлагаа өргөжүүлсэн явдал юм.⁵² Харин Эмнести Интернэшнл санал болгож байгаа энэхүү өөрчлөлт нь хэний эрх ашиг, эрх, тулгамдсан асуудлыг хэрхэн тодорхойлж, шийдвэрлэх талаар тодорхой тусгаагүй, эрээвэр хураавар зүйл болжээ гэж үзэж байна. Тухайлбал, Гүйцэтгэлийн стандартад нэр томъёог нэг мөр хэрэглээгүй тохиодол олон таарч байна. Шинэчилсэн бичвэрт “орон нутгийн иргэд”, “оролцогч талууд”, “нөлөөнд өртсөн оролцогч талууд” болон “бусад оролцогчид” гэсэн нэр томъёог хольж хэрэглэжээ.⁵³ Гүйцэтгэлийн 5 болон 7-р стандартад зөвхөн “орон нутгийн иргэд” гэсэн нэр томъёог хэрэглэсэн атлаа 1, 4-р Стандартад “орон нутгийн иргэд” болон “нөлөөнд өртсөн оролцогч талууд”

⁵¹ IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April, 2010, p 47 para 27, footnote 25.

⁵² IFC, *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process* 14 April 2010 p 12, para 40.

⁵³ The revised text of Performance Standard 1 refers to the “stakeholders” as being “workers, Affected Stakeholders, and other stakeholders”. “Affected Stakeholders” are defined as “people, groups, or communities, who are subject to actual or potential project-related risks and/or adverse impacts on their physical environment, health, or livelihoods and who are often located in the project’s near geographical proximity, particularly those contiguous to the existing or proposed project facilities”. “Other stakeholders” are defined as “those people or groups that are not located in the project’s geographical area of influence and have an interest in a project and/or ability to influence its outcomes”. See IFC, *Performance Standard 1, Rev-0.1, Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, (2010), p 43, footnotes 1, 2, 3 and 4.

гэсэн нэр томъёоны аль алиныг хэрэглэжээ.⁵⁴ Түүнчлэн шинэчилсэн эхэд “бусад сонирхогч талууд”,⁵⁵ “бусад талууд”⁵⁶ болон “голлох оролцогчид”⁵⁷ зэрэг нэр томъёог тодорхойлолт хийлгүйгээр ашиглажээ.

Ийнхүү нэр томъёог нэг мөр хэрэглээгүйгээс төслийн улмаас эрх нь зөрчигдөж байгаа хүмүүсийг олж тодорхойлох, үнэлэх, төслийн үр нөлөөг зохицуулахад тодорхойгүй байдал үүсгэж байна. Тухайлбал, Гүйцэтгэлийн 1-р стандартын “оролцогч талуудын” (өмнө нь орон нутгийн иргэд гэж дурдсан) оролцоотой холбоотой 22-р зүйлд “оролцогч талуудын оролцооны шинж чанар, давтамж, хүчин чармайлтын төвшин янз бүр байж болох бөгөөд нөлөөнд өртсөн оролцогч талуудад төслөөс үзүүлэх эрсдэл болон сөрөг нөлөөний хэмжээнээс хамаарна.” Гүйцэтгэлийн 1-р стандартын 27-р зүйлд “шууд нөлөөнд өртөгчдийг” нэн тэргүүнд анхаарахыг үйлчлүүлэгчдээс шаардсан боловч нэр томъёог нэг мөр хэрэглээгүйгээс (“орон нутгийн иргэд”, “оролцогч талууд”, “нөлөөнд өртсөн оролцогч талууд”, “талууд” гэх мэт) “шууд нөлөөнд өртсөн” гэж чухам хэнийг ойлгох нь тодорхойгүй болжээ.

“Нөлөөнд өртсөн оролцогч талууд” гэсэн нэр томъёог шинэчилсэн эхэд “амьдрах орчин, эрүүл мэнд, амьжиргаанд нь төсөлтэй холбоотой бодит буюу болзошгүй эрсдэл учирч байгаа, газар зүйн хувьд төслийн ойр орчимд буюу хэрэгжиж байгаа болон төлөвлөгдсөн төслийн байгууламжтай хил залган амьдарч байгаа хүмүүс, бүлгүүд болон орон нутгийн иргэд” гэж тодорхойлсон. Гэхдээ энэ тодорхойлолт тун ойлгомжгүй юм. Нэгдүгээрт, болзошгүй эрсдэл болон үр нөлөөний хүрээг (амьдрах орчин, эрүүл мэнд, амьжиргаа) аливаа төслөөс хүмүүст нөлөөлөх бүхий л үр нөлөөг хэтэрхий явцуу авч үзсэн. Хоёрдугаарт, нөлөөнд өртсөн оролцогч талууд газар зүйн хувьд төслөөс хол байх боломжтой. Тухайлбал, голын доод урсгалд амьдарч байгаа орон нутгийн иргэд төслөөс үүдэлтэй усны бохирдолд өртөж болох учраас “шууд нөлөөнд өртсөн” гэсэн ойлголтод хамаарах ёстой.

“Оролцогч талууд” гэдгийг тодорхойлохдоо орон нутгийн иргэд биш бөгөөд “төслийн газар зүйн байршлын хүрээнд амьдардаггүй боловч төсөлд тодорхой ашиг сонирхолтой буюу түүний үр дүнд нөлөө үзүүлэх чадвартай хувь хүмүүс болон бүлгүүдийг”, “бусад оролцогч талууд” хэмээн хамааруулан тусгасан байна. Эдгээр “бусад оролцогч талууд” гэдгийг төслийн шууд нөлөөнд өртсөн хэмээн тооцогдох боломжтой улс төр, эдийн засгийн хувьд нөлөө бүхий хувь хүн, компани буюу бүлгүүд гэж ойлгож болохоор байна. Энэ нь Гүйцэтгэлийн стандартад хүний эрхийг хүндэтгэн сахих талаар тусгах нь хичнээн чухал болохыг харуулж байна. Оролцогч талуудыг төслийн үйл ажиллагаанд

⁵⁴ Тухайлбал, НХБОТБ-ын шинэчилсэн хувилбарын төсөлд “санхүүжүүлэх гэж байгаа бизнесийн үйл ажиллагаа төслийн газар зүйн нөлөөний хүрээнд амьдарч байгаа нутгийн иргэдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд ...ОУСК үйлчлүүлэгчийн зүгээс орон нутгийн иргэдийг татан оролцуулах үйл ажиллагаа чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангасны үндсэн дээр зөвлөлдөх зарчмыг мөрдлөг болгохын хамт Нөлөөндөртсөн оролцогчдыг мөн мэдээллээр ханган оролцуулахад анхаарах ёстой.”, IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 34, para 24.

⁵⁵ Гүйцэтгэлийн 1-р стандартын шинэчилсэн эхэд уг стандартын зорилго бол “Нөлөөнд өртсөн оролцогч талууд болон бусад сонирхогч талуудыг төсөлтэй холбоотой хүрээлэн буй орчин, нийгмийн холбогдох мэдээллээр хангах явдал” гэж заасан. IFC, *Performance Standard 1, Rev-0.1, Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, p 44, 14 April 2010. See also the Disclosure Policy.

⁵⁶ The objectives in the revised Performance Standard 1 include: “To ensure that projects manage communications and grievances from Affected Stakeholders and other parties”, IFC Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 44.

⁵⁷ IFC, *Performance Standard 1, Rev-0.1, Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 50, para 23.

татан оролцуулахдаа төслийн улмаас хүний эрх нь шууд хөндөгдөж байгаа хүмүүс, нутгийн иргэдийн хүний эрхийг нэн тэргүүнд хүндэтгэн сахих тухай тодорхой шаардлагыг тусгах ёстой. Бусад оролцогч талуудын санаа бодол, хувь нэмэр чухал боловч тэр нь төслийн нөлөөнд өртсөн хүмүүсийн эрхийг хүндэтгэн сахих үндсэн үүргийг бүдгэрүүлэх учиргүй.

“ХАМГИЙН БАГА БАЙЛГАХ” ГЭДГИЙГ “БУУРУУЛАХ” ХЭМЭЭН СОЛЬСОН НЬ

Өмнө нь үйлчлүүлэгчид өөрсдийн үйл ажиллагааны сөрөг нөлөөг “хамгийн бага байлгах” шаардлагатай байсан бол шинэчилсэн бичвэрт тэдгээр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой үр нөлөөг “бууруулах” шаардлагатай гэж заажээ. Тодруулбал, Гүйцэтгэлийн 3-р стандартад үйлчлүүлэгчид төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдлоос сэргийлэх буюу түүнийг бууруулах замаар хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөнөөс сэргийлэх буюу түүнийг бууруулах (дээд зэргээр багасгах биш) үүрэгтэйг заасан.⁵⁸ Мөн Гүйцэтгэлийн стандартын 4-рт үйлчлүүлэгчид төслийн нөлөөнд өртсөн оролцогч талуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эрсдэл, сөрөг нөлөөнөөс сэргийлэх буюу түүнийг бууруулах (дээд зэргээр багасгах биш) үүрэгтэйг заасан.⁵⁹

Шинэчилсэн бичвэрт үйлчлүүлэгчдэд тавигдах шаардлагыг бууруулсан байгаа бөгөөд тухайлбал аюултай хог хаягдлыг бууруулах шаардлага тавьснаас биш илүү үр дүнтэй арга замаар аюултай хог хаягдал гаргахыг дээд зэргээр багасгах тухай заагаагүй. “Дээд зэргээр багасгах” гэсэн нэр томъёог ийнхүү өөрчилсөн нь үйлчлүүлэгчдэд хүний эрхийг хүндэтгэн сахих талаар хийх боломжтой төвшингөөс доогуур зүйлийг хийсэн ч ОУСК-ийн Тогтвортой хөгжлийн цар хүрээ баримт бичиг харшлахгүй юм байна гэсэн ойлголт төрүүлэхүйц болжээ. Жишээ нь, Гүйцэтгэлийн 4-р стандартад зааснаар зөвшөөрөлгүй газарт, стандарт зөрчин хог хаягдал хаясан тохиолдолд үйлчлүүлэгчид тэрхүү үйлдлийг нь хориглох бус харин “хог хаягдлыг бууруулах” үүрэгтэй гэж заажээ. Гүйцэтгэлийн 5-р стандартад зааснаар шилжүүлэн суурьшуулалтыг бууруулах гэснийг нэг хүнээр цөөн хүнийг шилжүүлэн суурьшуулснаар гүйцэтгэх боломжтой гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, шилжүүлэн суурьшуулалтыг дээд зэргээр багасгах бүх арга хэрэгслийг эрэлхийлэх шаардлагагүй болж байна.

ШИНЭЧИЛСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН СТАНДАРТАД ТУСГАГДААГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тогтвортой хөгжлийн цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн эхэд үйлчлүүлэгчид эрсдэл, үр нөлөөг тодорхойлохтой холбоотой асуудлыг хариуцах менежментийн тогтолцоо бий болгох ёстой гэж заасан. Тодруулбал, “эрсдэл ба үр нөлөөг тодорхойлсноор Шилжүүлэн суурьшуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Биологийн төрөл зүйлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Усны нөөцийн менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Орон нутгийн иргэдийн аюулгүй байдлын төлөвлөгөө, Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө болон Уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөгээрэг олон төрлийн төлөвлөгөө боловсруулж болно”⁶⁰ гэж заасан. Гэхдээ эдгээр төлөвлөгөөнөөс

⁵⁸ IFC, Performance Standard 3, Rev-0.1, *Resource Efficiency and Pollution Prevention*, p 61.

⁵⁹ IFC, Performance Standard 4, Rev-0.1, *Community Health, Safety, and Security*, p 68.

⁶⁰ See, for example, IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 48, fn 20.

хэд хэд нь Тогтвортой хөгжлийн цар хүрээнд огт тусгагдаагүй байна. Тухайлбал, Гүйцэтгэлийн стандарт 1-8-рт Биологийн төрөл зүйлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Аюултай хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээний талаарх үйл ажиллагааны төлөвлөгөө, Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөвлөгөө зэргийн талаар тодорхой заалт байхгүй буюу эсхүл тийм төлөвлөгөө боловсруулах шаардлагатай гэдгийг тусгаагүй байна. Шинэчилсэн бичвэрт нэр томъёог нэг мөр хэрэглэж, дээр дурдсан төлөвлөгөөг тодорхойлж, тэдгээрийг хэзээ боловсруулах шаардлагатайг тодорхой заах ёстой.

5. ОУСК-ИЙН НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОДЛОГО ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙГ УХАМСАРТАЙГААР САХИХ ЗАРЧИМ

Эмнести Интернэшнл 2006 онд ОУСК-ийн баталсан Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлогыг судлан үзээд төслийн болзошгүй үр нөлөөг тодорхойлох үйл явц хийгээд төсөлд тавих хөндлөнгийн болон удирдлагын хяналтад ноцтой алдаа дутагдал байгаа талаар саналаа илэрхийлсэн билээ. Тухайлбал, ОУСК үйлчлүүлэгчдийн өгсөн мэдээлэлд хэт тулгуурладаг, үр дүнтэй хяналт, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй зэрэг асуудлыг онцгойлон дурдсан. Гэвч эдгээр асуудлыг шинэчилсэн баримт бичигт огт тусгаагүй байна. Эмнести Интернэшнл Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлогын талаар дараахи зөвлөмжийг өгч байна:

Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлогод хүний эрхийг ухамсартайгаар сахих зарчмыг хатуу тусгах ёстой ба дараах үндсэн элементийг багтаах шаардлагатай:

1. ОУСК хүний эрхэд учирч болзошгүй эрсдэл болон үр нөлөөний талаар урьдчилсан үнэлгээ хийж байх, уг үнэлгээг төсөлтэй холбоотой аливаа шийдвэр, түүний дотор тухайн төслийг ОУСК дэмжих эсэх, уг төслийг хэрхэн ангилах зэрэг шийдвэр гаргахдаа харгалзан үзэх. Уг урьдчилсан үнэлгээг төсөлд хөндлөнгийн хяналт тавихад харгалзан үзэх.
2. ОУСК үйлчлүүлэгчдийн зүгээс хүний эрхийг ухамсартайгаар сахих зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаатай холбоотой үйлчлүүлэгчдээс өгсөн аливаа мэдээлэлд бие даасан хөндлөнгийн хяналт явуулж байх. (Гүйцэтгэлийн стандартын шинэчилсэн хувилбарт тусгах).
3. ОУСК дараахи мэдээллийг орон нутгийн иргэдэд өгч, хамтран ажиллана: (а) бизнесийн үйл ажиллагаан дахь ОУСК-ийн оролцоо, (b) ОУСК-ийн зүгээс үйлчлүүлэгчдэд тавьдаг шаардлага, (c) Бизнесийн үйл ажиллагааны үр нөлөөний талаар гомдол санал гаргах тохиолдолд хандах Хуулийн зөвлөх / Омбудсман буюу бусад арга хэрэгсэл байгаа эсэх.

5.1. ХҮНИЙ ЭРХИЙН ҮР НӨЛӨӨНИЙ УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

ОУСК-ийн үзэж байгаагаар 2006 онд батлагдсан Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн гол онцлог бол процесст бус харин үр нөлөөнд суурилсан нийгэм, хүрээлэн буй орчны ангиллыг ашигласан явдал юм.⁶¹ ОУСК тэрхүү ангилал нь үйлчлүүлэгч хүрээлэн буй орчин ба нийгмийн эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих үйл явцын үр дүнгээр тодорхойлогдох ёстой гэж тайлбарлаж байна. Нийгэм, хүрээлэн буй орчны тогтвортой байдлын бодлогын шинэчилсэн эхэд энэхүү өөрчлөлтийг “Санал болгосон бизнесийн үйл ажиллагааг нийгэм, хүрээлэн буй орчны болзошгүй эрсдэл, үр нөлөөнд үндэслэн ангилна” гэж онцлон заасан.⁶² Гэсэн хэдий боловч Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн хувилбарт ОУСК төслийн ангиллыг тодорхойлох асуудлаар үйлчлүүлэгчдээс хамааралгүйгээр бие даан мэдээлэл олж авах эрхтэй эсэх асуудлыг огт дурдаагүй орхисон байна. 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт Эмнести Интернэшнлийн өмнө нь өгч байсан санал дүгнэлтэд дурдсанчлан санал болгож байгаа аливаа төслийн хүний эрхийн үр нөлөөний талаар

⁶¹ IFC, *Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Report on the First Three Years of Application*, 29 July 2009, para 31.

⁶² IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 32, para 15.

урьчдилсан үнэлгээг ОУСК биечлэн хийх ёстой бөгөөд уг үнэлгээ нь холбогдох бусад мэдээллийн хамтаар уг төслийн талаарх ОУСК-ийн шийдвэр, түүний дотор төслийг ямар ангилалд багтаах (үүнд ОУСК-ийн санхүүгийн зуучлагчдаар дамжуулан санхүүжүүлж байгаа төсөл мөн хамаарна) зэргийг тусгасан байх ёстой. Түүнчлэн уг үнэлгээний үр дүнд ОУСК-ийн мэдээллийн сангийн шинжилгээ, үр нөлөөний үнэлгээ болон үйлчлүүлэгчийн зүгээс ОУСК-д гаргаж өгсөн бусад мэдээллийг багтаах ёстой.

5.2. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ БИЕ ДААН ШИНЖЛЭХ, БИЕЛЭЛТИЙГ ХӨНДЛӨНГӨӨС ХЯНАХ

ОУСК Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлого(НБОТББ)-ынхоо шинэчилсэн хувилбарын зорилго тодорхойлсон хэсэгт тус корпорацийн хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бүх асуудалд хүрээлэн буй орчин, нийгмийн үүрэг хариуцлагаа ухамсартайгаар хэрэгжүүлэх болно гэж заасан. Тэдгээр бизнесийн үйл ажиллагаанд шууд ба шууд бус хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээ зэрэг багтана. Ийнхүү зорилгодоо заасан боловч НБОТББ-ын үндсэн эхэд нийгэм, хүрээлэн буй орчин, хүний эрхийн аливаа эрсдэл, үр нөлөөг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах талаар бие даасан ажиллагаа явуулах ямар нэг үүргийг ОУСК-д хүлээлгээгүй байна. Шууд хөрөнгө оруулалтын хувьд ОУСК эрсдлийг тодорхойлж, үнэлэхдээ гол анхаарлаа үйлчлүүлэгчдээс ирүүлсэн материалыг хянаж үзэхэд чиглүүлэхээр байна.⁶³

Уг бодлогод зааснаар үйлчлүүлэгчдийн ирүүлсэн аливаа мэдээлэлд урьдчилсан, бие даасан үнэлгээ хийх буюу уг мэдээллийн үнэн зөв эсэхийг тогтоох ямар нэг үүргийг ОУСК-д хүлээлгээгүй байна. 2006 онд батлагдсан Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн нэгэн адил ОУСК-д тодорхой хүлээлгэсэн цорын ганц үүрэг бол үйлчлүүлэгчийн зүгээс хэрэгжүүлж байгаа орон нутгийн иргэдэд чиглэсэн аливаа үйл ажиллагаа тэдгээр иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангагдсан зөвшилцөл болон нутгийн иргэдийн өргөн дэмжлэгт үндэслэсэн эсэхийг олж тогтоох явдал юм.⁶⁴ Нутгийн иргэдийн өргөн дэмжлэг гэсэн ойлголтын талаар хойно 5.3-р хэсэгт тодорхой өгүүлнэ.

Гүйцэтгэлийн стандарт хэрхэн хэрэгжиж байгаад хөндлөнгийн хяналт тавих талаар Нийгэм, хүрээлэн буй орчны тогтвортой байдлын бодлогод маш бүрхэг заажээ. Уг бодлогын шинэчилсэн эхийн 15-р хэсэгт ОУСК-аас хөрөнгө оруулалт хийгдэж байгаа бүх хугацаанд тус корпораци үйлчлүүлэгчийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавина гэж заасан. 34-р хэсэгт энэ тухай илүү дэлгэрэнгүй заасан. Хөндлөнгийн хяналтын үйл

⁶³ The revised draft states: "IFC (i) assesses the client's social and environmental management system to verify its appropriateness in accordance with the nature and scale of the business activity and level of social and environmental risks and impacts; (ii) assists the client in developing measures to avoid, reduce, restore or compensate/offset for social and environmental impacts; (iii) categorizes the proposed business activity based on potential social and environmental risks and impacts; (iv) identifies risks and potential environmental and/or social impacts and defines conditions under which IFC financing for the business activity could proceed; and (v) monitors and supervises clients' ongoing performance in relation to those conditions throughout the life of IFC's investment." IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, pp 31-32, para 15; Para 23 of the revised draft states: "The social and environmental due diligence typically includes three key components: (i) review of the social and environmental risks and impacts of the business activity as assessed by the client; (ii) review of the commitment and capacity of the client to manage risks and impacts, including the client's social and environmental management system; and (iii) review of the potential role of third parties to meet the requirements of the Performance Standards." IFC *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 34, para 23.

⁶⁴ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, 30 April 2006, para 20, p 4, and IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 34, para 24.

явц олон талаар 2006 оны бодлоготой яг ижил байна. Хамгийн том өөрчлөлт гэвэл өмнө нь хөндлөнгийн хяналтыг тогтмол явуулах ёстой гэж заасан байсан бол одоо жил тутам явуулж байхаар тусгажээ. “Нийгэм, хүрээлэн буй орчны эрсдэл, сөрөг нөлөө үзүүлж болзошгүй” төсөлтэй газар дээр нь очиж танилцах талаар дурдсан хэдий ч тэдгээр төслийг хэрхэн тодорхойлох, ямар шаардлага тавих талаар тодорхой тусгаагүй заалт хэвээр үлджээ.

ОУСК-ийн санхүүгийн зуучлагчдаар дамжин санхүүжигддэг үйл ажиллагаа улам өсч, тус корпорацийн хийсэн хөрөнгө оруулалтын 40 орчим хувийг эзлэх болсон⁶⁵ энэ үед Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт тусгагдсан хамгийн нааштай зүйл бол бизнесийн бүх үйл ажиллагаанд уг баримт бичиг хамаарах болсон явдал юм. ОУСК өөрийн гаргасан CODE тайланд НХОТББ-ын шинэчилсэн хувилбарт хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих үзэл баримтлал шууд болон шууд бус хөрөнгө оруулалтад нэгэн адил хамаарах талаар тодорхой дурдсан.⁶⁶

НХОТББ-ын шинэчилсэн хувилбарт уг бодлогын гол зорилго бол ОУСК-ийн нийгэм, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах талаар хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэх, чингэхдээ ОУСК-ийн үйл ажиллагааны өргөн хүрээ, түүний дотор шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн зуучлагчдаар дамжин хийгдсэн хөрөнгө оруулалт, ОУСК-ийн Хөрөнгийн Менежментийн Компани болон зөвлөх үйлчилгээ зэрэгт нэгэн адил хамаарахаар заасан. Тухайлбал, шинэчилсэн бодлогын 2-р хэсэгт ОУСК эдгээр үүрэг амлалтаа нийцүүлэн, нийгэм, хүрээлэн буй орчны асуудлаархи Гүйцэтгэлийн стандартыг мөрдөн ажиллах тухай тусгасан.⁶⁷ Шинэчилсэн бодлогын 16-р хэсэгт нийгэм, хүрээлэн буй орчны асуудлаарх ОУСК-ийн хүлээсэн үүрэг хариуцлага хөрөнгө оруулалтын бүхий л үйл ажиллагаанд хамаарах ёстойг онцлон дурджээ.

Харин шууд бус хөрөнгө оруулалтын тухайд ОУСК нийгэм, хүрээлэн буй орчны эрсдлийг үнэлэх, шийдвэрлэх үүргийг бүхэлд нь санхүүгийн зуучлагчдад хүлээлгэсэн байна.⁶⁸ ОУСК шууд бус хөрөнгө оруулалтын асуудлаар хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахихтай холбоотой ганц заалт тусгагдсан нь “санхүүгийн зуучлагчдаар үйлчлүүлэгчдийн аливаа бизнесийн үйл ажиллагаа ОУСК болон түүний санхүүгийн зуучлагчдын хөрөнгө оруулалтад эрсдэл учруулж болзошгүй эсэх, учирсан эрсдлийг даван туулахад тавигдах шаардлагыг тодорхойлох” явдал юм.⁶⁹ Ингэхдээ Гүйцэтгэлийн 1-р стандартад заасанчлан санхүүгийн зуучлагчдын нийгэм ба хүрээлэн буй орчны менежментийн тогтолцоог хянан үзэх, тэрчлэн Гүйцэтгэлийн 2-р стандартыг өөрийн ажилчдаар мөрдүүлэх зэргийг багтаасан байна. Гэхдээ ОУСК болон санхүүгийн зуучлагчид өөрсдийн хөрөнгө оруулалтын улмаас эрсдэлд өртөх эсэхэд илүү анхаарал хандуулснаас бус тэдний үйл ажиллагаанаас үүдэн нийгэм, хүрээлэн буй орчин, хүний эрхийн эрсдэл учрах эсэхэд огт анхаараагүй байна. Ингэснээрээ ОУСК санхүүгийн зуучлагчдаар дамжуулан хэрэгжүүлж байгаа аливаа үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй хүрээлэн буй орчин, нийгэм, хүний эрхийн эрсдлийг тодорхойлох, үнэлгээ хийх үүргээ хөсөрдүүлж байна.

⁶⁵ IFC, *Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Report on the First Three Years of Application*, 29 July 2009, p 10, para 31.

⁶⁶ IFC, *Progress Report on IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, para 40, p 12, 14 April 2010, available at [http://www.ifc.org/ifcext/policyreview.nsf/AttachmentsByTitle/Phase2_CODEReport/\\$FILE/Compounded+CODE_Progress+Report+on+IFC%27s+Sustainability+Framework_Review+and+Update.pdf](http://www.ifc.org/ifcext/policyreview.nsf/AttachmentsByTitle/Phase2_CODEReport/$FILE/Compounded+CODE_Progress+Report+on+IFC%27s+Sustainability+Framework_Review+and+Update.pdf), last accessed 19 July 2010.

⁶⁷ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 29, para 2.

⁶⁸ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 35, para 26.

⁶⁹ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 35, para 27.

Шинэчилсэн эхэд “өндөр эрсдэлтэй дэд-төслийн нийгэм, хүрээлэн буй орчны менежментийн тогтолцооны үр дүнг тодорхойлох зорилгоор” газар дээр нь очиж мониторинг хийх тухай тусгасан.⁷⁰ Харамсалтай нь, түүнийг хэзээ хэрхэн явуулах талаар ямар нэг тодорхой зүйл заалт байхгүй байна.⁷¹ Мөн ОУСК санхүүгийн зуучлагчдад зээл олгосон дэд төслийн хөрөнгө оруулалтын нийгэм, хүрээлэн буй орчин, хүний эрхийн үр нөлөөний талаархи тайланг хянан үзэж “болох” боловч⁷² хувьцаа болон бусад төрлийн ерөнхий санхүүжилт олгосон тохиолдолд тийм эрх эдлэхгүй⁷³ гэж заасан.

5.3. ОУСК-ИЙН ЗҮГЭЭС НУТГИЙН ИРГЭДИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ

Эмнести Интернэшнлийн сэтгэл зовниж байгаа асуудлын нэг нь ОУСК үйлчлүүлэгчдийнхээ мэдээлэлд хэт найдаж, тэдгээр мэдээллийг хянаж үзэх идэвхитэй үүрэг гүйцэтгэж чадахгүй байгаа явдал юм. Эдгээр дутагдлыг арилгахад ОУСК-ийн зүгээс орон нутгийн иргэдийг оролцуулах явдал чухлаар тавигдаж байна. Ялангуяа, ОУСК тухайн төсөл дэх тус байгууллагын оролцоо болон төслөөс гарсны дараах үр дүнгийн талаар орон нутгийн иргэдээс мэдээлэл авах практик нэвтрүүлэх ёстой.

Мэдээлэл түгээх бодлогын шинэчилсэн эхэд зааснаар тухайн хөрөнгө оруулалтад ОУСК оролцох магадлалтай байгаа талаар “орон нутагт мэдээлэл түгээх” үүргийг үйлчлүүлэгчдэд хүлээлгэсэн.⁷⁴ Хэдийгээр энэ нь нааштай алхам боловч үйлчлүүлэгч төслийн нөлөөнд өртөж байгаа иргэдэд мэдээллийг ил тод болгох талаар яг ямар үүрэг хүлээхийг тодорхой заагаагүй нь учир дутагдалтай юм. Тэрчлэн, Хяналтын зөвлөх /Омбудсманы олж тогтоосноор үйлчлүүлэгч компаниуд орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх талаар маш их дутагдалтай байна.⁷⁵ Тиймээс, ОУСК орон нутгийн иргэдэд аливаа төсөл дэх тус корпорацийн оролцооны талаар мэдээлэл хүргэх өөрийн тогтолцоог бий болгох хэрэгтэй юм. Мөн ОУСК өөрийн үйлчлүүлэгчдэд тавьдаг шаардлага болон Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө орон нутгийн иргэдэд хүргэж байх ёстой. Хэдийгээр Мэдээлэл түгээх бодлогод Үйл ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд ил тод хүргэх тухай заасан байдаг⁷⁶ ч энэ нь ихэвчлэн тухайн баримт бичгийг интернэтэд байрлуулахыг хамарч байгаа нь орон нутгийн иргэдэд зохих ёсоор мэдээлэл хүргэхэд хангалтгүй юм. Хяналтын зөвлөх/Омбудсман саяхан “Үйл ажиллагааны төлөвлөгөөг олонх тохиолдолд орон нутгийн иргэдэд танилцуулдаггүй бөгөөд иргэд төслийн гүйцэтгэлийн ахиц дэвшлийн талаар цаг тухайд нь мэдээлэл авч чадахгүй байна” хэмээн мэдэгдсэн.⁷⁷ Орон нутгийн иргэд Үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар илүү мэдээлэл авснаар төслийн үр нөлөөний тухай илүү сайн ойлголттой болж, өөрсдийнх амьдралд нөлөө үзүүлэх төслийн талаар илүү бодитой шийдвэр гаргах боломжтой болно. Түүнээс гадна, ОУСК Үйл ажиллагааны төлөвлөгөө болон үйлчлүүлэгчдэд тавигддаг бусад шаардлагын талаар орон нутгийг иргэдийг

⁷⁰ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 37, footnote 2.

⁷¹ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 35, para 26.

⁷² IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 36, para 30.

⁷³ IFC, *Policy on Social and Environmental Sustainability*, Rev-0.1, 14 April 2010, p 36, para 29.

⁷⁴ *International Finance Corporation's Policy on Disclosure of Information*, revised draft, 2010, p 103, para 14(c)(xii).

⁷⁵ “Documented evidence demonstrated that just over half of the assessed projects that developed Action Plans were disclosed publicly by IFC client companies. ... None of these projects demonstrated that affected communities were updated at least annually on the Action Plan's implementation, as required by Performance Standard 1”: Compliance Advisor/Ombudsman, Advisory Note, *Review of IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability and Policy on Disclosure of Information*, May 2010, p 13.

⁷⁶ *International Finance Corporation's Policy on Disclosure of Information*, revised draft, 2010, p 102, para (a).

⁷⁷ Compliance Advisor/Ombudsman, Advisory Note, *Review of IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability and Policy on Disclosure of Information*, May 2010, p 3.

бүрэн дүүрэн мэдээллээр хангаснаар орон нутгийн мониторингийн үйл явцыг дэмжиж, үйлчлүүлэгчид хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар бодитой мэдээлэл авах боломж бүрдэнэ.

Одоогийн байдлаар ОУСК зөвхөн Орон нутгийн өргөн дэмжлэгийг тодорхойлохдоо хараат бус мэдээлэл авах ёстой боловч ингэхдээ орон нутгийн иргэдтэй шууд харилцах талаар тодорхой заалт байхгүй байна. ОУСК Эмнести Интернэшнлд мэдэгдэхдээ Орон нутгийн өргөн дэмжлэгийг тодорхойлохдоо Хүрээлэн буй орчин ба нийгмийн хяналтын журамд заасан⁷⁸ хэд хэдэн хүчин зүйлийг ашигладаг бөгөөд тэдгээр нь үндсэндээ үйлчлүүлэгчдээс гаргаж өгсөн бичиг баримтыг хянаж үзэх замаар хэрэгжүүлдэг гэсэн. Орон нутгийн иргэдтэй шууд харилцах асуудлыг маш хязгаарлагдмал байдлаар тусгажээ.⁷⁹

Түүнээс гадна ОУСК тухайн төслийг дэмжих буюу татгалзах эсэхээ судлаж байх явцдаа орон нутгийн иргэдэд зөвлөгөө өгөх үүрэг хүлээгээгүй. Тогтвортой байдлын цар хүрээ барим бичгийн шинэчилсэн хувилбарт Орон нутгийн өргөн дэмжлэгийг тодорхойлох үйл явцтай холбоотой мэдээллийгн тоймыг нийтэд ил тод болгох талаар заалт орсон.⁸⁰ Гэсэн хэдий боловч Эмнести Интернэшнл уг мэдээллийг төсөл бүрээр нарийвчлан гаргахыг шаардаж байна.

⁷⁸ IFC, *Environmental and Social Review Procedures Version 4.0*, (2009), pp 34-39.

⁷⁹ Determining BCS may include "Results of IFC site visit". One-to-one interviews are also suggested as one way of gathering evidence of good faith negotiations when required under Performance Standard 7.

⁸⁰ *International Finance Corporation's Policy on Disclosure of Information*, revised draft, 2010, para (d), p 102.

6. ГҮЙЦЭТГЭЛИЙН 1-Р СТАНДАРТ: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэлийн 1-р стандарт хүний эрхийг үр дүнтэйгээр, ухамсартайгаар хүндэтгэн сахих дараахи зүйлсийг тусгах ёстой. Үүнд:

1. Хүний эрхийн бодлого. ОУСК-аас дэмжлэг авахыг эрмэлзэж байгаа үйлчлүүлэгчид олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн бүхий л хүний эрхийг хүндэтгэн сахихаа илэрхийлсэн хүний эрхийн бодлоготой байх ёстой. Үйлчлүүлэгчид тэрхүү бодлого нь компаний менежментийн тогтолцоонд байр сууриа эзлэхийн зэрэгцээ зохих ёсоор хэрэгжиж, хяналт тавигддаг болохыг нотлох ёстой.
2. Хүний эрхийн үр нөлөөний үнэлгээ. ОУСК эцсийн санхүүжилт олгохын өмнө үйлчлүүлэгчдээсээ хүний эрхийн үр нөлөөний үнэлгээ гаргаж өгөхийг шаардах ёстой. Түүнийг хүрээлэн буй орчин, нийгмийн үр нөлөөний үнэлгээтэй хамт гаргаж өгс болох хэдий ч уг үнэлгээ нь хүний эрхийн үр нөлөөг тусгайлан үнэлсэн байх ёстой. Хүний эрхийн үр нөлөөний үнэлгээг хийхдээ дараах зарчмыг мөрдөнө. Үйлчлүүлэгчид төслийн үйл ажиллагаанд ямарваа байдлаар өртөж болзошгүй хүмүүсийг холбогдох бүх мэдээллээр цаг алдалгүй хангаж байх. Үйлчлүүлэгчид орон нутгийн иргэдийг шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжоор хангах ёстой бөгөөд төслийн үр нөлөөний үнэлгээг хүртээмжтэй хэлбэрээр танилцуулах ёстой.
3. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн бусад сөрөг үр нөлөөнөөс зайлсхийх болон тэдгээрийг багасгах талаар авах арга хэмжээг тусгайлан заах өгөх ёстой. Хүний эрхийн сөрөг үр нөлөө үзүүлэх эрсдэл бүхий төслийн хувьд ОУСК өөрийн үйлчлүүлэгчдээс тэдгээр эрсдлийг хэрхэн даван туулах асуудлыг нарийвчлан тусгасан Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахыг шаардах ёстой. Тэрхүү төлөвлөгөөг санхүүжилт олгох эцсийн шийдвэр гаргахаас өмнө ирүүлэх ёстой. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийг иргэдийг татан оролцуулах нь туйлын чухал.
4. Орон нутгийн иргэдийг татан оролцуулах. ОУСК-аас санхүүгийн дэмжлэг авч байгаа бүх үйлчлүүлэгч төслийн үр нөлөөнд өртөж байгаа орон нутгийн иргэдэд холбогдох мэдээлэл, түүний дотор Үйл ажиллагааны төлөвлөгөө, гомдол гаргах журмын тухай хэрхэн хүргэх, төсөл хэрэгжих явцад хүний эрх зөрчигдөж болзошгүй шийдвэр болон үйл ажиллагааны талаар тэдэнтэй хэрхэн зөвлөлдөж байх зэрэг асуудлыг нарийвчлан тайлбарлах ёстой.

6.1. ХҮНИЙ ЭРХИЙГ УХАМСАРТАЙГААР ХҮНДЭТГЭН САХИХ ЗАРЧИМ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БОЛОХ НЬ

Эмнести Интернэшнл 2006 онд батлагдсан Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт дүн шинжилгээ хийхдээ Гүйцэтгэлийн 1-р стандартад хүний эрхийн зарчмыг тусгасан нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвлөмж болгосон билээ. Гэтэл Гүйцэтгэлийн стандартын шинэчилсэн хувилбарт “Нийгэм, хүрээлэн буй орчны үнэлгээ ба менежментийн тогтолцоо” гэсэн хуучин гарчгийг “Нийгэм, хүрээлэн буй орчны эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент” гэж өөрчилснөөс өөр дорвитой нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Энэхүү өөрчлөлт нь зөвхөн үр нөлөө төдийгүй эрсдлийн менежментийг авч үзсэнээрээ ач холбогдолтой болсон боловч тэдгээрт хүний эрхийн үр нөлөө, эрсдлийг багтаагаагүй нь учир дутагдалтай болжээ. Өмнө дурдсанчлан,

хүний эрхийн тухай зөвхөн Гүйцэтгэлийн 1-р стандартын ишлэл хэсэгт л дурдсан байна.

Гүйцэтгэлийн 1-р стандартад дурдагдсан нийгэм, хүрээлэн буй орчны үнэлгээ, менежментийн тогтолцоонд тавигдах шаардлагууд: (1) бодлогын баримт бичиг; (2) эрсдэл, үр нөлөөг тодорхойлох тогтолцоо; (3) менежментийн тогтолцоо, төлөвлөгөө, гэрээ; (4) байгууллагын чадавх, чадамж; (5) онцгой байдлын бэлэн байдал; (6) оролцогч талуудыг татан оролцуулах; (7) мониторинг ба хяналт.⁸¹ Эдгээр 7 шаардлага 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт тусгагдсан байсан бөгөөд тэдгээрийг Бизнес ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн хэрэглэдэг нэр томъёотой нийцүүлэн шинэчилсэн байна.⁸² Хэдийгээр энэ нь зүйтэй алхам боловч ийнхүү нэр томъёог шинэчлэхдээ жинхэнэ агуулгыг нь тусгаж чадаагүй нь харамсалтай. Тухайлбал, бодлогын баримт бичигт хүний эрхийг хүндэтгэн сахих үүрэг амлалтыг заавал тусгаж байх, үнэлгээний үйл явцад хүний эрхийн үр нөлөөг заавал харгалзан үзэх зэрэг асуудлыг орхигдуулсан байна. Түүнээс гадна, ийнхүү засвар өөрчлөлт хийхдээ өмнө байсан ололттой зүйлс, тодруулбал Гүйцэтгэлийн стандартал тусгагдсан байсан нийгэм, хүрээлэн буй орчны менежменттэй холбоотой тайлан гаргаж өгөх үүргийг хассан байна.

Гүйцэтгэлийн 1-р стандартын дутагдалтай талыг Эмнести Интешнэшнл 2006 онд Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт хийсэн үнэлгээндээ онцлон дурдсан. Тэдгээр дутагдал шинэчилсэн эхэд ч хэвээр үлдсэн учраас дахин давтах шаардлагагүй гэж үзлээ. ОУСК Эмнести Интешнэшнлээс өмнө нь өгсөн санал зөвлөмжийг баримт бичигтээ зайлшгүй тусгах шаардлагатай. Дээрх санал зөвлөмжөөс гадна зарим нэг эерэг өөрчлөлтийг доор дурдав.

6.2. ГУРАВДАГЧ ТАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮДСЭН ЭРСДЭЛ

Гүйцэтгэлийн 1-р стандартын 2-рт үйлчлүүлэгчдийн зүгээс хяналт тавих буюу нөлөөлөх боломжгүй Засгийн газар ба бусад гуравдагч талын хариуцлагад хамаарах эрсдэл, үр нөлөөтэй холбоотой төвөгтэй асуудлыг хөнджээ. Компаниуд засгийн газар ба бусад гуравдагч талын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх эрхтэй эсэх асуудал туйлын ярвигтай боловч тийнхүү нөлөө үзүүлсэн олон жишээ байдаг.⁸³ Гүйцэтгэлийн 1-р стандартын дагуу үйлчлүүлэгчид “холбогдох байгууллагуудыг тодорхойлж, тэднээс үйлчлүүлэгчдэд үзүүлж болзошгүй эрсдлийг олж тогтоох” шаардлагатай. Гэхдээ гуравдагч талын зүгээс нутгийн иргэдэд үзүүлж болзошгүй хүний эрхийн болоод нийгэм, хүрээлэн буй орчны эрсдлийг үйлчлүүлэгчид тодорхойлох тухай дурдаагүй. Бусад талуудын үйл ажиллагаанаас нутгийн иргэдийн хүний эрх, нийгэм, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдлийг дутуу үнэлж болохгүй. Энэ нь ялангуяа, үйлчлүүлэгчдийг төслийн үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө засгийн газар буюу бусад гуравдагч талын зүгээс нутгийн иргэдийн эрхийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд илүү хамаарна.

⁸¹ IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 44, para 4.

⁸² The SRSG has outlined that corporate due diligence includes having a human rights policy, conducting impact assessments, integrating human rights policies throughout the company, and tracking performance. See Report of the Special Representative of the Secretary-General on the issue of human rights and transnational corporations and other business enterprises, John Ruggie, *Protect, Respect and Remedy: a Framework for Business and Human Rights*, A/HRC/85, 7 April 2008.

⁸³ For example, see case of Ok Tedi in Papua New Guinea described in footnote 19, above.

Үйлчлүүлэгчдийн хувьд төслөөс өмнө гарсан гомдлыг боломжтой бүх тохиолдолд авч үзэх нь зүтэй бөгөөд ингэснээр тэд цаашдын аливаа үйл ажиллагаандаа өмнөх шударга бус үйлдлийг даамжруулахаас сэргийлж чадна. Гэвч шинэчлэн найруулсан Гүйцэтгэлийн 1-р стандартын 2-рт үйлчлүүлэгчдэд зөвхөн холбогдох талууд болоод тэдний үүрэг роль, “үйлчлүүлэгчдэд тэдний зүгээс учруулж болзошгүй эрдслийг” тодорхойлох үүрэг хүлээлгэсэн байна.⁸⁴ Уг заалтад ОУСК-ийн үйлчлүүлэгчид тухайн бүс нутаг буюу төслийн хүрээнд шинэ үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө уг газарт гуравдагч талын үйл ажиллагааны улмаас учирсан хүний эрхийн болоод хүрээлэн буй орчны эрсдлийг олж тогтоох, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга хэрэгслийг үнэлэх тухай нэмж оруулах ёстой.

6.3. ЧАНАРТАЙ ТУЛГУУР ТОО БАРИМТ

Шинэчилсэн хувилбарт эрсдэл, үр нөлөөг тодорхойлохдоо “сүүлийн үеийн” нийгэм, хүрээлэн буй орчны тулгуур тоо баримтыг “зохих төвшний нарийвчлалтайгаар” ашиглах ёстой гэж заасан. Хэдийгээр тоо баримт сүүлийн үеийнх байх ёстой гэсэн шаардлага нь дэвшилттэй зүйл боловч бусад төрлийн тоо баримтын талаар хангалттай дурдаагүй байна.

6.4. ХАВСАРСАН ҮР НӨЛӨӨ

Гүйцэтгэлийн 1-р стандартад оруулсан нэг нааштай өөрчлөлт бол хавсарсан үр нөлөөг өргөн хүрээнд авч үзэхээр болсон явдал юм. Өмнө нь үйлчлүүлэгчид зөвхөн “төсөлтэй холбоотой” үйл ажиллагааны хавсарсан үр нөлөөг тодорхойлох үүрэг хүлээж байсныг төсөлтэй холбоогүй үйл ажиллагаанд нэгэн адил хамааруулахаар болсон.⁸⁵ Түүнээс гадна үйлчлүүлэгчид төслийн хүрээнд төлөвлөгдөөгүй боловч хийгдэж болзошгүй үйл ажиллагаа үүдэн гарах үр нөлөөг харгалзан үзэх шаардлагатай болсон. Эмнести Интернэшнлийн зүгээс хавсарсан үр нөлөөг ийнхүү өргөн хүрээнд авч үзэх болсныг нааштайгаар хүлээн авч байна.

6.5. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Гүйцэтгэлийн 1-р стандартын шинэчилсэн эхэд заасны дагуу үйлчлүүлэгчдээс заавал өргөдөл гомдол шийдвэрлэх механизм бий болгохыг шаарддаг болсон. Урьд нь зөвхөн үйлчлүүлэгч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд түүнийг ашигладаг байв. Санал болгож байгаа өөрчлөлт нааштай зүйл хэдий ч ОУСК өөрийн үйлчлүүлэгчдээс уг өргөдөл гомдол шийдвэрлэх механизм нь Бизнес ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн илтгэлд дурдсан зарчимд нийцэж байх ёстой гэсэн шаардлага тавихгүй байгаа нь сэтгэл гонсоймоор зүйл юм. Тэдгээр зарчмыг⁸⁶ дурдвал:

- о **Хууль ёсных байх.** Уг механизм нь өргөдөл гомдол гаргасан аль нэг тал шийдвэр гаргах үйл явцад хөндлөнгөөс оролцохгүй байх нөхцлийг хангахын тулд ойлгомжтой, ил тод, хангалттай бие даасан удирдлагын бүтэцтэй байх ёстой.

⁸⁴ IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 43, para 2.

⁸⁵ IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 46, para 7.

⁸⁶ Protect, Respect and Remedy: *a Framework for Business and Human Rights*. UN Special Representative on human rights and Transnational Corporations and other entities, June 2008, (A/HRC/8/5), paras 92-95.

- **Хүртээмжтэй байх.** Хэл, бичиг үсэг мэдэхгүй байх, тухайн асуудлаар ойлголт сул, санхүүгийн боломжгүй, алслагдсан газар амьдардаг, халдлагад өртөхөөс эмээх зэрэг саад тотгортой учирч болзошгүй гомдол гаргагч талуудад уг механизмын талаар сурталчлан таниулах ёстой.
- **Ойлгомжтой байх.** Уг механизм нь үе шат бүрт ямар хугацаа шаардагдах, ямар үйл ажиллагаа явагдах, ямар шийдвэрт хүрч болох, тэрхүү шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зэргийг ойлгомжтой, тодорхой тусгасан байх ёстой.
- **Эрх тэгш байх.** Холбогдох талууд гомдол шийдвэрлэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, мэргэжлийн туслалцаа зэргийг шударга, эрх тэгш үндсэн дээр авах зохих боломжоор хангагдах ёстой.
- **Хүний эрхэд нийцсэн байх.** Шийдвэр гаргах механизм нь олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байх ёстой.
- **Ил тод байх.** Олон нийтийн сэтгэлийг түгшээж байгаа асуудлаарх өргөдөл гомдлыг шийдвэрлэх бүхий л үйл явц аль болох ил тод байх ёстой бөгөөд ялангуяа төрийн бус механизмын хувьд гомдол хүлээж авсан тухай болон ямар шийдвэр гаргасан тухай гол гол мэдээлэл нийтэд ил тод байх ёстой.

Тэрчлэн өргөдөл гомдол шийдвэрлэх механизм нь шууд болон зуучлагчаар дамжуулан яриа хэлэлцээ явуулах боломжийг хангах ёстой.⁸⁷

Бизнес ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч компаний төвшин дэх өргөдөл гомдол шийдвэрлэх механизмийг “түүнд хандах магадлал бүхий бүлгийн төлөөгчидтэй хамтран байгуулж, үйл ажиллагааг нь хамтран хянах ёстой” хэмээн онцлон тэмдэглэсэн. Гэтэл Гүйцэтгэлийн 1-р стандартын шинэчилсэн хувилбарт “зарим тохиолдолд холбогдох талуудын санал дүгнэлтэд үндэслэн өргөдөл гомдол шийдвэрлэх механизмийн бүтцийг тогтоож болно” гэж заасан байна.⁸⁸ Онцгой шалтгаанаас үүдэн орон нутгийн иргэдийг татан оролцуулах боломжгүй байх тохиолдлоос бусад нөхцөлд төслийн төвшин дэх өргөдөл гомдол шийдвэрлэх механизмийг бий болгоход орон нутгийн иргэдийг оролцуулж байх нь зүйтэй гэж Эмнести Интернэшнл үзэж байна.

⁸⁷ *Protect, Respect and Remedy: a Framework for Business and Human Rights*. UN Special Representative on human rights and Transnational Corporations and other entities, June 2008, (A/HRC/8/5), para 95

⁸⁸ IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 53, para 31.

7. ГҮЙЦЭТГЭЛИЙН 3, 4, 5, 7-Р СТАНДАРТЫН ШИНЭЧИЛСЭН ХУВИЛБАР

1. Гүйцэтгэлийн 2-8 -р стандартыг дахин хянаж, олон улсын хүний эрхийн гэрээ конвенци, хэм хэмжээг тусгах.

Эмнести Интернэшнл 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт санал дүгнэлт гаргахдаа дөрвөн гүйцэтгэлийн стандарт хүний эрхийн хэм хэмжээтэй зөрчилдөж байгаад голлон анхаарсан билээ. Тиймээс, энэхүү баримт бичигт тэдгээр стандарт буюу 3, 4, 5, 7-р стандартад санал дүгнэлт өгөх болно.

7.1. ГҮЙЦЭТГЭЛИЙН 3-Р СТАНДАРТ

Хүний эрхийн мониторингийн байгууллагууд, олон улсын болон үндэсний шүүхийн байгууллагууд хүрээлэн буй орчны доройтол хийгээд хүний эрхийн зөрчил хоёр өөр хоорондоо уялдаатай гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрөх болсон.⁸⁹ Хүрээлэн буй орчны бохирдол нь хүнс тэжээл, ундны ус, орон байраар хангагдах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, амьд явах эрхийг зөрчихөд хүргэдэг. Гүйцэтгэлийн 3-р стандартын шинэчилсэн хувилбарт “Үйлчлүүлэгч тухайн төслийн нийгэм, хүрээлэн буй орчны эрсдэл, үр нөлөөг тодорхойлох ёстой”⁹⁰ бөгөөд чингэхдээ “хүн амын эрүүл мэнд, хүний эрх, хүйсийн ялгаатай байдал болон усны хүртээмж зэрэгтэй холбоотой эрсдэл, үр нөлөөг тодорхойлох ёстой”⁹¹ гэж заасан. Гэвч хүрээлэн буй орчны бохирдол, түүнээс сэргийлэх асуудалтай холбоотой Гүйцэтгэлийн 3-р стандартад бохирдлоос үүдэн хүний эрхэд нөлөөлж болзошгүй эрсдэл, үр нөлөөг тодорхойлох, арга хэмжээ авах талаар үйлчлүүлэгчид тодорхой үүрэг хүлээлгээгүй байна. Мөн нутгийн хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой Гүйцэтгэлийн 3,4-р стандартад тодорхойгүй заалт хэвээр үлджээ.

Эрүүл мэндийн эрх нь хүрээлэн буй орчны бохирдлын улмаас сөрөг нөлөөнд өртөж болох хүний эрхийн нэг мөн. Эрүүл мэндийн эрхэд чанартай, тохирсон үнэтэй, ёс заншилдаа нийцэхүйц эмнэлгийн үйлчилгээ авах, эрүүл байхын үндэс болсон цэвэр ус, хоол хүнс, эрүүл ахуйн нөхцөл, орон байраар хангагдах эрх багтана. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо эрүүл мэндийн эрхийн гол үндсэн тодорхойлолтонд “эрүүл орчин” мөн хамаарах ёстой гэж зарласан.⁹² Түүнчлэн уг Хороо эрүүл мэндийн эрхэд “хүний эрүүл мэндэд шууд буюу дам сөрөг нөлөө үзүүлж болох цацрагийн бохирдол, химийн хортой бодис зэрэг хүрээлэн буй орчны аюултай нөхцөл байдлаас сэргийлэх буюу, түүнийг бууруулах” асуудлыг эрүүл мэндийн эрхэд

⁸⁹ See for example: Declaration of the United Nations Conference on the Human Environment, available at: <http://www.unep.org/Documents/multilingual/Default.asp?DocumentID=97&ArticleID=1503>, last accessed 20 July 2010, para 1; African Commission on Human and Peoples' Rights, Decision on Communication of the Social and Economic Rights Action Center (SERAC) and Center for Economic and Social Rights (CESR) v Nigeria (155/96), para 54. The decision was adopted at the 30th ordinary session of the African Commission of Human and Peoples' Rights, Banjul, 13-27 October 2001. SERAC and CESR v Nigeria available at <http://www1.umn.edu/humanrts/africa/comcases/155-96b.html>, last accessed 20 July 2010.

⁹⁰ IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 45, para 6.

⁹¹ IFC, Performance Standard 1, Rev-0.1, *Assessment and Management of Social and Environmental Risks and Impacts*, 14 April 2010, p 45, para 6, footnote number 7.

⁹² Committee on Economic, Social and Cultural Rights, General Comment No. 14: The Right to the Highest Attainable Standard of Health (Art. 12 of the International Covenant on Economic, Social and Cultural Rights), UN Doc E/C.12/2000/4, 11 August 2000, para 4.

хамааруулж авч үзэхээр шийдвэрлэсэн байдаг.⁹³

Бусад хүний эрхийн нэгэн адил ялгаварлан гадуурхах явдлаас ангид байх нь эрүүл мэндийн эрхийн гол тулгуур зарчим юм. Хэдийгээр Гүйцэтгэлийн 3-р стандартад хүн амын эрүүл мэндийн талаар дурдсан боловч, ОУСК-ийн үйлчлүүлэгчид хүний эрүүл мэндийн эрхэд хүрээлэн буй орчны бохирдлын үзүүлж болох үр нөлөөг тодорхойлох, арга хэмжээ авах, хяналт тавих талаар тодорхой заалт алга байна. Тухайлбал, Гүйцэтгэлийн 3-р стандартын шинэчилсэн хувилбарт үйлчлүүлэгчид “хүний эрүүл мэндийн эрх болоод хүрээлэн буй орчинд үзүүлж болох сөрөг нөлөөнөөс сэргийлэх, тийм боломжгүй бол түүнийг бууруулах” зорилгоор хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх зарчим, техник хэрэгслийг хэрэглэх ёстой гэж заасан.⁹⁴ Гүйцэтгэлийн 3-р стандартын шинэчилсэн хувилбарын 12-т дээрхтэй нэгэн адилаар “үйлчлүүлэгчид хүрээлэн буй орчныг бохирдуулагч зүйлс гаргахаас зайлсхийх, тийнхүү зайлсхийх боломжгүй тохиолдолд хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлхийхийн тулд бохирдуулагчийг их хэмжээгээр гаргах явдлыг бууруулах буюу хяналтандаа байлгах ёстой”⁹⁵ гэж заасан. Гэвч, Эмнести Интерншенлийн 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт өгсөн санал дүгнэлтэд дурдсанчлан энэ заалтад үйлчлүүлэгч төсөлтэй холбоотой бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа үр нөлөөг тодорхойлох үүрэг хүлээх эсэх, төсөл хэрэгжих хугацаанд түүнд хяналт тавих, хариу арга хэмжээ авах талаар тодорхой заалт алга байна. Түүнээс гадна, Гүйцэтгэлийн 3-р стандартад үйлчлүүлэгчдэд хүн амын эрүүл мэндийн эрхийг хангах зорилгоор холбогдох дүрэм журмыг боловсруулан мөрдөх үүрэг хүлээлгээгүй байна.

БОХИРДЛЫН ЯЛГАВАРТАЙ ҮР НӨЛӨӨ

Гүйцэтгэлийн 3-р стандартад хүрээлэн буй орчныбохирдлын хүйсийн ялгавартай үр нөлөөг тодорхойлох, арга хэмжээ авах талаар тодорхой тусгаагүй байна. Эмнести Интерншенлийн 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт өгсөн санал дүгнэлтэд дурдсанчлан хүрээлэн буй орчны бохирдол нь ус авах, гэр бүлийнхээ ариун цэврийг сахих, ургац хураах зэрэг үүргийг ихэнхидээ гүйцэтгэдэг эмэгтэйчүүд, охидод илүүтэй сөрөг нөлөө үзүүлдэг билээ. Гэтэл энэ байдлыг эс харгалзан Гүйцэтгэлийн 3-р стандартад бохирдлын хүйсийн ялгаатай үр нөлөөг үнэлэх, хариу арга хэмжээ авах талаар ямар нэг шаардлага үйлчлүүлэгчдэд тавиагүй байна. Хэдийгээр Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн бусад хэсэгт хүйсийн тэгш байдлын талаар нааштай хэд хэдэн заалт орсон боловч Гүйцэтгэлийн 3-р стандартад бүхэлдээ хүйсийн тэгш байдал ба эмэгтэйчүүдтэй холбоотой ямар ч заалт алга байна.

Тэрчлэн Гүйцэтгэлийн 3-р стандартад хүрээлэн буй орчны бохирдол тухайн нутгийн иргэдийн зарим хэсэгт илүүтэй эрсдэл, сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эсэхийг харгалзан үзэх шаардлага үйлчлүүлэгчдэд тавиагүй. Хүний эрхийн эрх зүй эрсдэлд байгаа хувь хүмүүс хийгээд бүлгийн эрхийг тодорхойлох, хамгаалах талаар тусгайлсан арга хэмжээ авахыг шаарддаг. Орон нутгийн зарим иргэдэд хүрээлэн буй орчны бохирдолд илүү эмзэг байх төрөл бүрийн шалтгаан байж болно. Хүүхэд, өндөр

⁹³ Committee on Economic, Social and Cultural Rights, General Comment No. 14: The Right to the Highest Attainable Standard of Health (Art. 12 of the International Covenant on Economic, Social and Cultural Rights), UN Doc E/C.12/2000/4, 11 August 2000, para 15.

⁹⁴ IFC, Performance Standard 3, Rev-0.1, *Resource Efficiency and Pollution Prevention*, p 62, para 4.

⁹⁵ IFC, Performance Standard 3, Rev-0.1, *Resource Efficiency and Pollution Prevention*, p 65, para 12.

настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн буюу хөхүүл эхчүүд болон дархлалын хомсдолтой болон эрүүл мэндийн бусад асуудалтай хүмүүс хүрээлэн буй орчны бохирдлоос үүдэлтэй эрсдэлд өртөх магадлал илүү өндөр байдаг.

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ДОРОЙТОЛ БА БОХИРДОЛ

Хүрээлэн буй орчны доройтол ба бохирдол хүйсийн болон бусад эмзэг байдлаас үүдэн ялгавартай нөлөө үзүүлдэг болохыг Эмнести Интернэшнл баримтжуулсаар ирсэн. Тухайлбал, ОУСК-ийн санхүүжүүлсэн төсөл биш боловч Нигерийн гурвалжин дахь газрын тосны үйлдвэрлэл жирэмсэн эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байгаа талаар тайлан гаргасан. Тус бүс нутгийн газар тос олборлодог Эбоха хэмээх газрын байгалийн хийг шатаах технологийн улмаас жирэмсэн эмэгтэйчүүд ядарч сульдан, уг газрыг орхин явахаас аргагүйд хүрсэн байна. Байгалийн хийг шатаах технологи асар үр ашиггүй, хүрээлэн буй орчинд хор хөнөөлтэй гэдгийг эртнээс хүлээн зөвшөөрөх болсон хэдий ч Нигерийн олон компани уг технологийг ашигласаар байна.⁹⁶ Эмнести Интернэшнл уг технологийн сөрөг нөлөөний талаар анагаахын шинжээчидтэй зөвлөлдсөн. Лондонгийн Эрүүл ахуй, халуун орны анагаах ухааны сургуулиас гаргадаг Олон улсын хүрээлэн буй орчны эрүүл мэнд сэтгүүлийн (International Environmental Health at the London School of Hygiene & Tropical Medicine) редактор Др. Каролин Стефенсийн үзэж байгаагаар “хэдийгээр байгалийн хийг шатаах технологи жирэмсэн эмэгтэйчүүдэд шууд нөлөө үзүүлдэг талаар нотолгоо байхгүй ч жирэмсэн эхчүүд агаар дахь хорт бодис болон газрын тостой холбоотой хордолтод илүү өртөмтгий байдаг бөгөөд зарим тохиолдолд гэнэтийн зулбалтанд ч хүргэдэг”.⁹⁷

Тиймээс ОУСК Гүйцэтгэлийн 3-р стандартад хүрээлэн буй орчны бохирдолд хүргэж болзошгүй үйл ажиллагаа явуулж байгаа өөрийн үйлчлүүлэгчдээс орон нутгийн иргэдэд хүрээлэн буй орчны бохирдлын үзүүлж болзошгүй ялгавартай үр нөлөөг тодорхойлох, хүний эрхэд учрах эрсдлийг тодорхойлох, арга хэмжээ авах талаар тодорхой шаардлага тавих ёстой.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХЭЭС БУСАД ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ БОХИРДЛЫН ҮР НӨЛӨӨ

Тэрчлэн Гүйцэтгэлийн 3-р стандарт хүрээлэн буй орчны бохирдлын улмаас хүний эрх, тэр дундаа цэвэр ус, хоол хүнс, зохих амьжиргааны төвшингөөр хангагдах эрхэд үзүүлэх эрсдлийг тодорхойлох шаардлагыг үйлчлүүлэгчдэдээ тавигүй байна. Усны асуудлаар зарим нэг жижиг дэвшил гарсан хэдий ч тэдгээр нь ундны усаар хангагдах эрхийг хамааруулаагүй байна.

2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт усны хэрэглээний талаар цухас дурдсан бол Гүйцэтгэлийн 3-р стандартын шинэчилсэн хувилбарт энэ талаар тодорхой заалт орсон байна. Хэдийгээр энэ нь нааштай зүйл боловч төслийн усны хэрэглээ “бусдад хэт сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийхийн тулд усны хэрэглээнээс

⁹⁶ Environmental Rights Action and The Climate Justice Programme, “Gas Flaring in Nigeria: A humanrights, environmental and economic monstrosity”, June 2005. In this report the authors quote from British government documents in the 1960s that show awareness of gas flaring as a problem. For more information, see Amnesty International, *Petroleum, pollution and poverty in the Niger Delta*, AI Index: AFR 44/017/2009, June 2009, p 18.

⁹⁷ Cited in Amnesty International, *Petroleum, pollution and poverty in the Niger Delta*, AI Index: AFR44/017/2009, June 2009, p 36.

зайлсхийх буюу түүнийг багасгах” арга хэмжээ авахыг үйлчлүүлэгчдээс шаардсан байна. Ингэснээр, Гүйцэтгэлийн 3-р стандарт үйлчлүүлэгчдийн үйл ажиллагаа ахуйн хэрэгцээний усны хүртээмж, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх тодорхой заалтыг багтааж чадсангүй.⁹⁸

Хангалттай, аюулгүй, хүртээмжтэй ундны устай байх нь ундны усаар хангагдах эрхийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эрүүл мэнд, хоол хүнсээр хангагдах эрхтэй салшгүй холбоотой. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо ундны усаар хангагдах эрхэд уг эрхийг эдлэхэд шаардлагатай усан хангамжийн системийг ашиглах эрхтэй байх, тэрхүү усан хангамж нь бохирдолт, хордлогоос ангид байх эрх зэрэг мөн хамаарна гэж үзсэн.⁹⁹ Гүйцэтгэлийн 3-р стандарт хүрээлэн буй орчны бохирдол хувь хүмүүс хийгээд нутгийн нийт иргэдийн ундны цэвэр усаар хангагдах, усанд орох, хувцсаа угаах зэрэг ахуйн бусад зориулалтаар ашиглах цэвэр усаар хангагдах эрхэд хэрхэн сөргөөр нөлөөлж болох талаар хангалттай анхаарал хандуулаагүй байна.

Мөн түүнчлэн, олон улсын хэм хэмжээнд нийцсэн дүрэм журмыг тусгаагүй байна. Ундны усаар хангагдах эрхтэй холбоотойгоор түүнд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө аюулгүй байдлын зохих дүрэм журам мөрдөгдөх ёстой. Эдгээрт дараах зүйлс багтана:

- а. Эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүстэй зөвлөлдөх бололцоотой байх.
- б. Авах арга хэмжээний талаар цаг алдалгүй, бүрэн дүүрэн мэдээлэл өгөх.
- в. Санал болгож байгаа арга хэмжээний талаар урьдчилан мэдэгдэх.
- г. Эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүст хуулийн дагуу нөхөн төлбөр олгох.
- д. Хуулийн дагуу нөхөн төлбөр авах талаар хууль зүйн туслалцаа үзүүлэх.¹⁰⁰

Түүнээс гадна, Гүйцэтгэлийн 3-р стандартад усыг үйлдвэрлэлийн зорилгоор ялгаварлалгүй хэрэглэсний улмаас бусад төрлийн усны эх сурвалжгүй хувь хүмүүс болон, нутгийн нийт иргэд зэрэг эмзэг хүн амд үзүүлэх эрсдлийг тодорхойлох, арга хэмжээ авах талаар үйлчлүүлэгчдэд ямар нэг үүрэг хүлээлгээгүй байна.

Усны бохирдлын нэгэн адил хөрс, агаарын бохирдлоос үүдэх сөрөг нөлөө нь нутгийн хүн амын хүнс тэжээлээ тариалах, ургац хураахад мөн нөлөөлж болно. Өөрөөр хэлбэл, ус, хөрс, агаарын бохирдол нь нутгийн иргэдийн тариалан, загас агнуур, мал аж ахуйгаас олох орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг.

⁹⁸ Гүйцэтгэлийн 4-р стандартын шинэчилсэн эхэд төслийн хүрээнд байгалийн баялгийг ашигласны улмаас буюу өөрчилснөөс нутгийн иргэдэд үзүүлэх үр нөлөөний талаар дурдсан. (т. 70, 8-р мөр). Эдгээр үр нөлөөнд “нутгийн иргэдийн хүртэх экосистемийн үр шим, тухайлбал усны хангамж буурах” зэрэг багтана гэсэн. Гүйцэтгэлийн стандарт үйлчлүүлэгчдээс эдгээр сөрөг нөлөөнөөс зайлсхийхийг шаардсан ч хэрхэн зайлсхийх талаар дурдаагүй бөгөөд нөлөөнд өртсөн нутгийн иргэд хувийн, ахуйн, хөдөө аж ахуйн хэрэгцээний цэвэр усны хангамжид ямар нөлөө үзүүлэх талаар үнэлгээ хийх шаардлага үйлчлүүлэгчдэд тавиагүй байна.

⁹⁹ Committee on Economic, Social and Cultural Rights, General Comment No. 15 (2002), The right to water (arts. 11 and 12 of the International Covenant on Economic, Social and Cultural Rights), E/C.12/2002/11, 20 January 2003, p 4, para 10.

¹⁰⁰ The UN Committee on Economic, Social and Cultural Rights has stated: “Before any action that interferes with an individual’s right to water is carried out by the State party, or by any other third party (emphasis added), the relevant authorities must ensure that such actions are performed in a manner warranted by law, compatible with the Covenant, and that comprises: (a) opportunity for genuine consultation with those affected”, Committee on Economic, Social and Cultural Rights, General Comment No. 15 (2002), The right to water (arts. 11 and 12 of the International Covenant on Economic, Social and Cultural Rights), E/C.12/2002/11, 20 January 2003, p 17, para 56.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ӨӨРИЙН ШИЙДВЭР

Гүйцэтгэлийн 3-р стандарт болон Тайлбарт хүрээлэн буй орчны бохирдлоос зайлсхийх болон түүнийг бууруулах талаар ямар арга хэмжээ авах талаар үйлчлүүлэгчид ихэвчлэн өөрсдөө шийдвэрлэх боломж олгосон байна. Гүйцэтгэлийн 3-р стандартын шинэчилсэн хувилбарт техникийн ба санхүүгийн боломжтой холбоотой хоёр заалтыг хассан¹⁰¹ боловч бохирдлоос зайлсхийх болон түүнийг бууруулах арга хэмжээ авахдаа дээр дурдсан өргөн хүрээтэй ойлголтыг ашигласан хэвээр байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН БЭЛЭН БАЙДАЛ

Эмнести Интерншенлийн 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт өгсөн санал дүгнэлтэд онцгой байдлын бэлэн байдалтай холбоотой заалт нь хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих зарчимд нийцэхгүй байгаа талаар дурдсан билээ. Гэтэл Гүйцэтгэлийн 3-р стандартын шинэчилсэн хувилбарт онцгой байдлын бэлэн байдалтай холбоотой бүх заалтыг хасчээ. Хэдийгээр Гүйцэтгэлийн 1-р стандартад онцгой байдлын бэлэн байдалд орон нутгийн иргэдийг татан оролцуулах талаар нэлээд заалт оруулсан боловч тийм үйл ажиллагаанд хүрээлэн буй орчны бохирдлын асуудлыг зайлшгүй тусгах шаардлагатай юм. Тиймээс Гүйцэтгэлийн 1-р болон 3-р стандартын аль алинд энэ асуудлыг тусгах ёстой бөгөөд ингэхдээ шинэчилсэн хувилбарын Гүйцэтгэлийн 1, 2, 4-р стандартын заалттай нийцүүлэхийг зөвлөмж болгож байна.

7.2. ГҮЙЦЭТГЭЛИЙН 4-Р СТАНДАРТ

Гүйцэтгэлийн 4-р стандартад нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдлийг тодорхойлох, арга хэмжээ авах асуудлыг тусгасан. Тухайлбал, барилга байгууламж, хортой материал, байгалийн гамшиг, өвчний тархалт болон хамгаалалтын албаны ашиглалт зэрэгтэй холбоотой асуудлыг хамрахыг хичээсэн байна. Гүйцэтгэлийн 3-р ба 4-р стандартын давхацсан заалтуудыг эс харгалзан, Гүйцэтгэлийн 4-р стандартад хүний эрүүл мэндэд хүрээлэн буй орчны бохирдлын үзүүлэх сөрөг нөлөөний талаар Гүйцэтгэлийн 3-р стандартад дурдсан гэж заажээ. Гэвч өмнө дурдсанчлан, Гүйцэтгэлийн 3-р стандартад хүрээлэн буй орчны бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний талаар хангалттай тусгаж чадаагүй гэж үзэж байна.

Гүйцэтгэлийн 4-р стандартын шинэчилсэн хувилбарт хамгаалалтын албаны ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахтай холбоотойгоор хүний эрхийн тухай хөндсөн байна. Тодруулбал, боловсон хүчин, өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй үндсэн болон гэрээт ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд үйлчлүүлэгчид олон улсын хүний эрхийн зарчим, хүмүүнлэгийн эрх зүйг мөрдөх

¹⁰¹ Paragraph 4 of the revised text removes the qualification that only technically and financially feasible and cost-effective measures would be required in the application of "resource efficiency and pollution prevention principles and techniques that are best suited to avoid, and if not possible, reduce adverse impacts on human health and the environment". Somewhat confusingly the footnote that explained the terms, "technical feasibility" and "financial feasibility", remains in the revised text. See IFC, Performance Standard 3, Rev-0.1, *Resource Efficiency and Pollution Prevention*, pp 61-62, para 4. Paragraph 15 also represents an improvement, replacing the word "feasible" with the word "possible", so as to prioritize the avoidance of using or generating hazardous materials, however the feasibility of these measures is reintroduced at the end of the sentence: "The client will avoid or, when avoidance is not possible, reduce and/or control the use and/or generation of hazardous materials as far as feasible" (emphasis added). See IFC, Performance Standard 3, Rev-0.1, *Resource Efficiency and Pollution Prevention*, p 66, para 15.

ёстой гэж заасан. Мөн үйлчлүүлэгчид аюулгүй байдлыг хангах ажилтнууд нь өмнө нь хүний эрхийн зөрчилд холбогдож байгаагүйг нотлох “зохих ёсны асуулга” явуулах ёстой гэсэн. Хэдийгээр хүний эрхтэй холбоотой эдгээр заалтыг Гүйцэтгэлийн 4-р стандартад оруулсан нь нааштай зүйл боловч бичвэрийн зөвшөөрсөн аяс хийгээд тодорхой бус байдал зэрэг нь шаардлага хангахгүй байна. Үйлчлүүлэгчид хамгаалалтын ажилтнуудаас НҮБ-аас баталсан Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм, Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хүч ба галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчим болон Аюулгүй байдал ба хүний эрхийн асуудлаарх сайн дурын зарчмууд зэргийг мөрдөхийг шаардах ёстой.¹⁰²

Гүйцэтгэлийн 4-р стандартад хамгаалалтын ажилтнуудтай холбоотойгоор хүний эрхийн асуудлыг ийнхүү дурдсанаас өөр хүний эрхтэй холбоотой тодорхой заалт байхгүй байгаа нь эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой хүний эрхийн болзошгүй эрсдлийг тодорхойлох, арга хэмжээ авах асуудлыг тэр чигт нь орхигдуулахад хүргэжээ. Гүйцэтгэлийн 3-р стандартад заасны нэгэн адил Гүйцэтгэлийн 4-р стандартад хортой хог хаягдлыг хэрэглэх буюу хаяснаас үүдэх эрсдлийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг тэдгээр хог хаягдал нь амь насанд аюултай байсан тохиолдолд ч нэгэн адил орон нутгийн иргэдэд түгээх үүргийг үйлчлүүлэгчдэд хүлээлгээгүй байна. Гүйцэтгэлийн 4-р стандартын шинэчилсэн хувилбарт төслийн улмаас нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд тэдэнд Үйл ажиллагааны төлөвлөөгөө болон төсөлтэй холбоотой бусад мэдээллийг гаргаж өгөх үүргийг хассан байна.¹⁰³ Өмнөх хувилбарт үйлчлүүлэгчид төслийн үйл ажиллагаанд өртсөн иргэд болон засгийн газрын агентлагуудыг үйл ажиллагаандаа тогтмол татан оролцуулах ёстой гэж заасан байв. Эдгээр шаардлагыг стандартаас хассан нь ололтоосоо ухарсан хэрэг юм. Дээр дурдсанчлан, төслийн үр нөлөөнд өртөж болзошгүй хувь хүмүүс, нутгийн иргэдийг зохих мэдээллээр хангаж байх нь хүний эрхийг баталгаатай хангахад амин чухал зүйл билээ.

Гүйцэтгэлийн 4-р стандартад орон нутгийн иргэдэд учирч болзошгүй зарим нэг эрсдлийн талаар огтхон ч дурдалгүй орхижээ. Тухайлбал, орон нутгийн иргэдэд учирч болзошгүй эрсдлийг тодорхойлохдоо “өвчинд тулгуурласан” хандлагыг ашиглаж байгаа нь бусад төрлийн эрсдлийг орхигдуулахад хүргэжээ. Жишээ нь, тус стандартын 9,10-рт төслийн түр болон байнгын ажиллах хүч олон тоогоор орж ирэхтэй холбоотойгоор төрөл бүрийн өвчин, түүний дотор халдварт өвчин нутгийн иргэдэд тархах эрсдлээс зайлсхийх буюу бууруулах үүргийг үйлчлүүлэгчдэд оногдуулсан боловч болон нийгмийн бусад сөрөг үр нөлөөний талаар огт тусгаагүй байна. Тэдгээрт ялангуяа эрэгтэй ажилчид хэт давамгайлсан тохиолдолд хүйсийн ялгавартай сөрөг нөлөө мөн багтаж болох юм. Тухайлбал, архи, мансууруулах бодисын хэрэглээ өсөх, хувь хүний аюулгүй байдал буурах, бэлгийн хүчирхийлэл ихсэх, төсөлд ажилд орох боломжгүй нутгийн эрчүүд ад шоо үзэгдэх эсхүл нутгийн иргэд төсөлд ажилд орсноос уламжлалт хөдөлмөрийн хуваарь өөрчлөгдөх, ингэснээр эмэгтэйчүүдийн ачаалал нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар бий болж болох юм. Түүнчлэн нийгмийн эдгээр сөрөг үр дагавраас

¹⁰² Code of Conduct for Law Enforcement Officials, Adopted by General Assembly resolution 34/169 of 17 December 1979, <http://www2.ohchr.org/english/law/codeofconduct.htm>, last accessed 20 July 2010; Basic Principles on the Use of Force and Firearms by Law Enforcement Officials, Adopted by the Eighth United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders, Havana, Cuba, 27 August to 7 September 1990, <http://www2.ohchr.org/english/law/firearms.htm>, last accessed 20 July 2010; Voluntary Principles on Security and Human Rights, <http://www.voluntaryprinciples.org/>, last accessed 20 July 2010.

¹⁰³ IFC, Performance Standard 4, Rev-0.1, *Community Health, Safety, and Security*, p 69, deleted para 6

үүдэн гэр бүлийн хүчирхийлэл ч нэмэгдэж болзошгүй.

Өмнөх хувилбарт үйлчлүүлэгчид “ялангуяа нутгийн иргэд өртөх магадлалтай тохиолдолд” байгалийн гамшигт үзэгдэлд илүү анхаарал тавихыг шаардсан заалт байсан бол шинэчилсэн хувилбарт уг заалт зөвхөн шинэ барилга, байгууламж барих тохиолдолд л хамаарахаар болсон байна. Мөн Гүйцэтгэлийн 4-р стандартын 6-д төслийн аливаа байгууламжийн зураг төслийг хийх, барих, ажиллуулах, ажиллагааг нь зогсоох явцад хүмүүст гэмтэл бэртэл учруулахаас зайлсхийх үүрэг үйлчлүүлэгчид хүлээлгэсэн хэдий ч бусад сөрөг үр дагаврын талаар ямар нэг зүйл дурдаагүй байна.

7.3.ГҮЙЦЭТГЭЛИЙН 5-Р СТАНДАРТ

Эмнести Интернэшнл 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт санал дүгнэлт гаргахдаа Гүйцэтгэлийн 5-р стандартын заалт иргэдийг шилжүүлэн суурьшуулах явцад хүний эрхийг хангах талаар асар их дутагдалтай байгааг дурдсан билээ. Ялангуяа, төслийн улмаас иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглосон заалт огт байхгүй байгаа юм. Түүнчлэн уг стандартын хамрах хүрээ маш хязгаарлагдмал бөгөөд зөвхөн төсөлд зориулан газар авснаас үүдсэн бодит болон эдийн засгийн шилжин суурьшилтад хамаарахаас бус төслөөс үүдэн газар ашиглалт ба газрын олдоцод гарсан үр нөлөөнд хамаарахгүй юм. Түүнчлэн уг стандарт олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу зөвхөн бусад бүх хувилбарыг харгалзан үзсэний дараа, холбогдох иргэдтэй сайтар зөвлөлдсөний үр дүнд эцсийн арга хэмжээ болгон нүүлгэн шилжүүлэх зарчмыг тусгаагүй байна.¹⁰⁴

Гүйцэтгэлийн 5-р стандартад иргэдийг нүүлгэн шилжүүлэхээс өмнө дагаж мөрдөх ёстой журмыг тусгаагүй байна. Уг журам нь олон улсын эрх зүйд харш албадан нүүлгэхээс зайлсхийхэд амин чухал зүйл юм.¹⁰⁵ Санаа зовоосон бусад асуудлыг дурдвал: амьдрах өөр газар санал болгох талаар тавигдах шаардлага сул¹⁰⁶, нүүлгэн шилжүүлэлтээс болж орон гэргүй болсон хүмүүст орон байр олгох тухай заалт тодорхой бус¹⁰⁷, шилжин суурьших газар нь орон байраар хангагдах эрхийн тухай олон улсын эрх зүйгээр тавигддаг 7 шаардлагыг заавал хангах тухай тодорхой тусгаагүй¹⁰⁸ зэрэг болно.

¹⁰⁴ Committee on Economic, Social and Cultural Rights General Comment No. 7, The right to adequate housing (Article 11(1) of the Covenant): forced evictions, para 13; Committee on Economic, Social and Cultural Rights General Comment No. 4, The right to adequate housing, (Article 11(1) of the Covenant), para 18.

¹⁰⁵ Үүнд дараах зүйлс багтана: а) эрх ашиг нь хөндөгдөж буй хүмүүстэй сайтар зөвлөлдөх; б) тэдгээр хүмүүст нүүлгэн шилжүүлэх товыг зохих ёсоор урьдчилан мэдэгдэх; в) нүүлгэн шилжүүлэлтийн талаар болон шаардлагатай тохиолдолд тухайн газар, орон байрыг ямар зорилгоор цаашид ашиглах гэж байгаа талаар эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүх хүнд хангалттай хугацааны өмнө мэдэгдэх; [...]. г) шүүхээр эрхээ хамгаалуулах; д) шүүхэд хандах хүсэлтэй хүмүүст эрх зүйн туслалцаа үзүүлэх. Committee on Economic, Social and Cultural Rights General Comment No. 7, The right to adequate housing (art. 11.1 of the Covenant): forced evictions, para 15.

¹⁰⁶ The 2006 version of Performance Standard 5, stated that “where livelihoods of displaced persons are land-based; or where land is collectively owned, the client will offer land-based compensation, *where feasible*” (emphasis added), Performance Standard 5, *Land Acquisition and Involuntary Resettlement*, 30 April 2006, para 8.

¹⁰⁷ The Committee on Economic, Social and Cultural Rights has stressed that “Evictions should not result in individuals being rendered homeless or vulnerable to the violation of other human rights”, General Comment No. 7, The right to adequate housing (Article 11(1) of the Covenant): forced evictions, para 16.

¹⁰⁸ These requirements are 1) legal security of tenure; 2) availability of services, materials, facilities and infrastructure; 3) location; 4) habitability; 5) affordability; 6) accessibility; and 7) cultural adequacy, Committee on Economic, Social and Cultural Rights, General Comment No. 4, The right to adequate housing, (Art. 11 (1) of the Covenant), para 8.

АЛБАДАН НҮҮЛГЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ТАЛААР ХАНГАЛТГҮЙ ТУСГАСАН НЬ

Гүйцэтгэлийн 5-р стандартын шинэчилсэн хувилбарт зарим нэг дэвшилттэй зүйл гарсан хэдий ч төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй хүний эрхийн эрсдэл, үр нөлөөг тодорхойлох, зохих арга хэмжээ авах талаар дутуу дулимаг зүйлс байсаар байна. Ялангуяа, Гүйцэтгэлийн стандартад албадан нүүлгэх талаар болон нүүлгэх, шилжүүлэн суурьшуулах ажиллагаа олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөхгүй байх ёстой талаар тодорхой заагаагүй нь ихээхэн санаа зовоож байна. Гүйцэтгэлийн 5-р стандартын зорилгыг тодорхойлсон хэсэгт хэл найруулгын хувьд зарим нааштай өөрчлөлт хийгдсэн¹⁰⁹ ч төслийн улмаас ямарваа албадан нүүлгэлт гарах ёсгүй гэдгийг тодорхой заагаагүй хэвээр байна. Энэхүү зорилгыг хүлээн зөвшөөрөх нь үйлчлүүлэгчдэд Гүйцэтгэлийн 5-р стандартын гол зорилго бол хүмүүсийг албадан нүүлгэлтээс хамгаалах, улмаар ОУСК ба үйлчлүүлэгчид хэрэгжүүлж байгаа төсөл нь хүний эрхийн зөрчилд хүргэхгүй байх явдлыг хангах үүрэг хүлээх ёстойг баталгаажуулах ач холбогдолтой. Гүйцэтгэлийн стандартын эх хувилбар болон шинэчилсэн хувилбарын аль алинд аливаа нүүлгэн шилжүүлэлт олон улсын хэм хэмжээг зөрчихгүй байх явдлыг хангасан шаардлагатай арга хэрэгслийг тусгаж чадаагүй байна.¹¹⁰

ХАМРАХ ХҮРЭЭ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ

Гүйцэтгэлийн стандарт төсөлд зориулан газар олгохоос авахуулаад газрын хэрэглээг хязгаарлах хүртэл хүрээг хамрахаар заажээ.¹¹¹ Энэ нь төсөлд зориулан газар олгох болон газрын хэрэглээг хязгаарласнаас үүдэн тухайн газрыг өмчлөх буюу байнга ашигладаггүй боловч ан агнах, уламжлалт зан үйл үйлдэх зэргээр ашигладаг нутгийн иргэдэд учрах сөрөг нөлөөг багасгах талаар нааштай зүйл болжээ. Гэвч түүний хажуугаар Гүйцэтгэлийн стандартад зохих ёсоор тусгагдаагүй зүйлс байна. Тухайлбал, Гүйцэтгэлийн 5-р стандартын шинэчилсэн хувилбарт төслийн улмаас тухайн газрыг ашиглах боломжгүй болгох бохирдол, доройтлоос үүдэх эрсдлийг тодорхойлох, арга хэмжээ авах талаар үйлчлүүлэгчдэд өгөх тодорхой зааварчилгаа алга байна. Уг стандартын 8-рт тийм төрлийн эрсдэл, үр нөлөөний Гүйцэтгэлийн 1-р стандартын дагуу арга хэмжээ авна гэж заасан байна. Мөн Гүйцэтгэлийн 5-р стандартыг мөрдөх эсэхийг үйлчлүүлэгч өөрөө сонгохоор байна.¹¹² Газраа ямар нэг байдлаар алдаж байгаа

¹⁰⁹ IFC, *Performance Standard 5, Rev-0.1, Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 72.

¹¹⁰ Олон улсын хэд хэдэн хүний эрхийн гэрээ конвенциор хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглох, түүнээс сэргийлэх үүргийг засгийн газрууд хүлээдэг. Үүнд, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 11-р зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17-р зүйл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 5-р зүйл зэргийг дурдаж болно. Эрүүдэн шүүхийн эсрэг хороо тодорхой тохиолдол албадан нүүлгэн шилжүүлэх явдал нь харгис, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон шийтгэх шинжтэй бөгөөд Эрүүдэн шүүлийн эсрэг конвенцийн 16-р зүйлд харш гэж мэдэгдсэн. (*see Hajrizi Dzemailj v Yugoslavia, UN Doc. CAT/C/29/D/161/2000, 2 December 2002*). ОУСК-ийн бүх гишүүн улс эдгээр гэрээ конвенцийн дор хаяж аль нэгэнд нэгдэн орсон байдаг. Safeguard measures that should be applied to all evictions have been clearly articulated by the UN Special Rapporteur on Adequate Housing in the Basic Principles and Guidelines on Development-based Evictions and Displacement (referred to as the Basic Principles), which reflect existing standards and jurisprudence on this issue. See: Annex 1 of the report A/HRC/4/18 of the Special Rapporteur on adequate housing as a component of the right to an adequate standard of living, considered by the Human Rights Council in 2007, available at http://www2.ohchr.org/english/issues/housing/docs/guidelines_en.pdf, last accessed 20 July 2010.

¹¹¹ IFC, *Performance Standard 5, Rev-0.1, Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, paras. 1, 5, 6 and 7.

¹¹² The revised text of Performance Standard 5 states that only if such impacts “become significantly adverse [...] with resulting physical and/or economic displacement” that clients “should consider” applying Performance Standard 5. See: IFC, *Performance Standard 5, Rev-0.1, Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 74, para 8.

хүмүүст адилхан хамгаалалт эдлүүлэх ёстой. Тиймээс Гүйцэтгэлийн 5-р стандартыг өргөжүүлж, төслийн улмаас үүдэн гарах бодит болон эдийн засгийн шилжин суррьшилттай холбоотой бүх нөхцөл байдлыг хамруулах ёстой.

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХЭЭС ӨӨР ХУВИЛБАРЫН ТАЛААР НУТГИЙН ИРГЭДТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ НЬ

Эмнести Интернэшнл 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт санал дүгнэлт гаргахдаа Гүйцэтгэлийн 5-р стандартыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой олон улсын хэм хэмжээнд нийцүүлж, нүүлгэн шилжүүлэх асуудлаар нутгийн иргэдтэй зөвлөлдөх талаар тодорхой заалт оруулах хэрэгтэйг онцолсон билээ. Эмнести Интернэшнл нүүлгэн шилжүүлэхээс өөр ямар хувилбар байгаа талаар болон нутгийн иргэдэд учрах сөрөг үр нөлөөг хэрхэн багасгах, хамгийн ядуу, эмзэг хэсгийнхэнд учирч болзошгүй ялгавартай үр нөлөөний талаар үнэлгээ хийхдээ зайлшгүй анхаарч байхыг шаардсан.

Гүйцэтгэлийн 5-р стандартын 11-рт орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх, тэднийг мэдээллээр хангах талаар найруулгын нэлээд нааштай өөрчлөлт гарчээ. Шинэчилсэн хувилбарт төслийн үйл ажиллагаанд өртсөн хувь хүмүүс, нутгийн иргэдтэй төсөлтэй холбоотой гол гол асуудал, түүний дотор нөхөн төлбөрийн хэмжээ, нөхөн төлбөр авахад тавигдах шаардлага, шилжин суурьшихад үзүүлэх туслалцаа, шилжин суурьшуулахаар санал болгосон газар тохиромжтой эсэх, нүүлгэх хугацаа зэргийн талаар зөвлөлдөж байна гэж заасан. Ийнхүү тодорхой асуудлыг тоочин оруулсан нь зүйтэй бөгөөд бусад гүйцэтгэлийн стандартад ч үүнийг нэгэн адил хэрэглэх шаардлагатай юм.

ХҮНИЙ ЭРХИЙГ УХАМСАРТАЙГААР ХҮНДЭТГЭН САХИХ ШААРДЛАГЫГ ОРХИГДУУЛСАН НЬ

Нутгийн иргэдтэй зөвлөлдөх талаар хийгдсэн нааштай өөрчлөлтийн хажуугаар шинэчилсэн хувилбарт хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахихад тавигдах олон шаардлагыг орхигдуулжээ.

Эмнести Интернэшнл 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт өгсөн санал дүгнэлтдээ нүүлгэн шилжүүлэлт явуулахаас өмнө тодорхой дүрэм журам мөрдөгдөх ёстой талаар ямар нэг заалт байхгүй байгааг шүүмжилсэн билээ. Шинэчилсэн хувилбарт ч нэгэн адил нүүлгэн шилжүүлэх өдрөөс хангалттай хугацааны өмнө шаардлагатай мэдээлэл иргэдэд өгөх, ямар нэг байдлаар түүнд өртөх бүх хүмүүсийг хангалттай хугацааны өмнө мэдээллээр хангах, нүүлгэн шилжүүлэх үед төрийн байгууллагын төлөөлөгчдийг байлцуулах, нүүлгэхэд орролцож байгаа бүх ажилтны нэр хаяг тодорхой байх, холбогдох иргэд зөвшөөрснөөс бусад тохиолдолд цаг агаар муу байхад буюу шөнийн цагаар нүүлгэхгүй байх, эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой шаардлагуудыг орхигдуулсан байна.

Эдгээр шаардлага нь нүүлгэн шилжүүлэх ажил хүний эрхийг ухамсартайгаар хүндэтгэн сахих зарчимд үндэслэхийн хамт холбогдох иргэдэд эрх зүйн туслалцаа авах, нүүлгэлтийн үед хүч хэрэглэх явдлаас зайлсхийх, тийнхүү хүч хэрэглэх тохиолдолд хуулийн дагуу гүйцэтгэх явдлыг хангахад зайлшгүй чухал зүйл юм. Тэрчлэн эдгээр

шаардлага нь тухайн нутгийн иргэдэд эд хөрөнгө болон барилгын материалаа авч явах, нүүлгэлтийн үед хамгийн эмзэг, ядуу хэсгийнхэнд хамгаалалт эдлүүлэх бололцоо олгоно.

ОУСК томоохон хэмжээний уурхай, газрын тос, байгалийн хий болон дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх явцад албадан нүүлгэх ажиллагааг байнга явуулсаар ирсэн. Тухайлбал, 2010 оны эхний хагаст ОУСК Филиппин, Аргентин, Танзани, Ботсвана, Этиоп, Кувейт, Марокко, Гана, Буркина Фасо зэрэг улсад хэрэгжих уурхай, газрын тос, байгалийн хийн төслийг авч хэлэлцсэн бөгөөд 3 уурхайн төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.¹¹³ Эмнести Интернэшнл олборлох үйлдвэрлэлийн хүрээнд хамгаалалтын албаныхан дээр дурдсан шаардлагуудыг дагаж мөрдөөгүйн улмаас иргэдийг хүч хэрэглэн нүүлгэн шилжүүлсэн тохиолдлуудыг бүртгэсэн. Тухайлбал, 2009 оны 4-р сард Папуа Шинэ Гвиней улсын Поргера алтны уурхайн ойролцоо амьдардаг тосгоны иргэдийг цагдаагийнхан хүчээр нүүлгэсэн явдлыг дурдаж болно.¹¹⁴ Цагдаагийнхан хүмүүсийн гэр орныг шатааж, тэднийг амь зулбан зугтахаас аргагүйд хүргэсэн. Олон тохиолдолд тэдэнд эд хогшлоо авах боломж олгоогүй бөгөөд амьдрах өөр орон байр гаргаж өгөөгүй учраас хамаатан садан, найз нөхдөө бараадахаас өөр арга үлдээгүй байна. ОУСК-ийн санхүүжилттэй нүүлгэн шилжүүлэлтийн үед хүний эрхийг зөрчсөн талаар бусад байгууллагууд ч мөн мэдээлсэн.¹¹⁵

ОУСК-ийн санхүүжүүлдэг төслийн дийлэнхи нь албадан нүүлгэлт хэрэглэдэг салбарт хамаардаг учраас тус корпорацийн гүйцэтгэлийн стандарт албадан нүүлгэлтийн талаар тусгайлан заагаагүй нь учир дутагдалтай юм. Гүйцэтгэлийн 5-р стандартад үйлчлүүлэгчид албадан нүүлгэлтээс сэргийлэхийн тулд шат дараалан ямар арга хэмжээ авах талаар тодорхой заалт оруулах ёстой. Гэтэл Гүйцэтгэлийн 5-р стандартад нүүлгэн шилжүүлэлтийг эхлүүлэхээс өмнө мөрдөх дүрэм журам хийгээд тийм дүрэм журам байхгүй бол ОУСК-д мэдээлэх талаар үйлчлүүлэгчдэд ямар нэг үүрэг оногдуулаагүй байна. Энэ нь маш ноцтой зүйл бөгөөд ОУСК болоод түүний гишүүн орнууд, үйлчлүүлэгчдэд ОУСК-ийн санхүүжүүлсэн төслийн хүрээнд иргэдийг албадан нүүлгэх, хүний эрхийг зөрчих эрсдлийг бий болгож байна. ОУСК Гүйцэтгэлийн 5-р стандартад тус корпораци хэрэв зохих шаардлага хангагдаагүй тохиолдолд ямарваа нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой төслийг санхүүжүүлэхгүй гэдгээ тодорхой тусгах ёстой. Үүнд нүүлгэн шилжүүлэхээс өөр хувилбар байгаа талаар нутгийн иргэдтэй зөвлөлдөх, түүнийг зөвхөн хамгийн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх зэрэг мөн хамаарна.

¹¹³ Information on proposed investments available at <http://www.ifc.org>, last accessed 16 July 2010; "IFC Invests in Helio to Support Future Jobs in Tanzania's Mining Industry" 27 Jan 2010 available at <http://www.marketwire.com/press-release/INC-Invests-in-Helio-to-Support-Future-Jobs-in-Tanzanias-Mining-Industry-1108372.htm>, last accessed 21 July 2010; "IFC Supports Solomon Islands Mining Sector with US\$35 million Loan to Gold Ridge Mining", 24 June 2010, available at <http://www.ifc.org/ifcext/media.nsf/content/SelectedPressRelease?OpenDocument&UNID=7186B79C5AF1A8048525774C0057D50B>, last accessed 21 July 2010; "IFC Investment in Mindoro Resources Supports Responsible Mining in the Philippines", 14 July 2010, available at <http://www.ifc.org/ifcext/media.nsf/content/SelectedPressRelease?OpenDocument&UNID=AF7A719FD2C1A0C785257760007547DD>, last accessed 21 July 2010.

¹¹⁴ Amnesty International, *Undermining Rights. Forced evictions and police brutality around the Porgera gold mine, Papua New Guinea*, AI Index: ASA 34/001/2010, January 2010.

¹¹⁵ See, for example, concerns raised regarding the impending eviction of 79 families affected by an IFC-supported airport expansion project in Cambodia: BIC, *Communities speak out against displacement*, (June 2010), available at <http://www.bicusa.org/en/Article.11896.aspx>; CAO complaint submitted by a local Cambodian NGO on behalf of 79 families affected by the airport project, available at http://www.cao-ombudsman.org/cases/case_detail.aspx?id=155. The CAO complaint relates to improper land acquisition and compensation, loss of livelihoods, noise pollution, environmental impact to national park, incorrect categorization, lack of community consultation, and inadequate disclosure of project information to impacted communities.

Тэрчлэн хэрэв ОУСК төслийн явцад албадан нүүлгэлт явагдсан бөгөөд түүнийг засах арга хэмжээ авагдаагүй тохиолдолд тухайн төслийг санхүүжүүлэхээ зогсоох т алаар тодорхой заалт оруулах ёстой.

ШИЛЖИН СУУРЬШУУЛАХ БА НӨХӨН ТӨЛБӨР

Эмнести Интернэшнл өмнө нь ч гэсэн Гүйцэтгэлийн 5-р стандарт дахь шилжүүлэн суурьшуулах болон нөхөн төлбөртэй холбоотой олон дутагдлыг шүүмжилж байсан билээ. Тэдгээр дутагдлын олонх нь шинэчилсэн хувилбарт хэвээр үлдсэн байна. Тодруулбал, газартай холбоотой нөхөн төлбөрийн талаар зөвхөн “боломжтой нөхцөлд”¹¹⁶ олгохоор заасан бөгөөд “ашиглаж байгаа болон эзэмшиж байгаа газраа өмчлөх хууль ёсны нотолгоо байхгүй бол боломжтой нөхцөлд бэлэн мөнгөний оронд бусад хэлбэрээр нөхөн төлбөр олгох”¹¹⁷ үүргийг үйлчлүүлэгчдэд хүлээлгэсэн. Шинэчилсэн хувилбарт газартай холбоотой нөхөн төлбөрийн талаар гарсан нэг нааштай өөрчлөлт бол эдийн засгийн болон бие махбодын хувьд шилжин суурьшихад хүрсэн хүмүүст хуучин газар буюу байгалийн нөөц баялаг нь амь амьжиргаагаа залгуулах ганц эх үүсвэр болдог байсан бөгөөд нөхцөл байдлын улмаас үйлчлүүлэгч өөр газар олгох боломжгүй байгаа тохиолдолд “нэн тэргүүнд” нөхөн олговор олгох ёстой гэж заасан.¹¹⁸ Гэвч энэхүү заалт нь үйлчлүүлэгч мөрдөж ч болох мөрдөхгүй байж ч болох шаардлагуудын жагсаалтад багтжээ.¹¹⁹ Цаашлаад, ОУСК үйлчлүүлэгчээс нөхцөл байдлын улмаас өөр газар олгох боломжгүй байгаа талаар өгсөн мэдээллийг хэрхэн нягтлах талаар тодорхой заалт алга байна.

Ерөнхийдөө Гүйцэтгэлийн стандартад тун өчүүхэн дэвшил гарчээ. Шинэ эхэд нүүлгэн суурьшуулах болон нөхөн олговрын талаар хөндлөнгийн аудит хийлгэх шаардлага үүсэж “магадгүй”¹²⁰ бөгөөд иргэдийн хүсэл сонирхлыг нэн тэргүүнд харгалзан үзэж, өмнө нь байсан нийгэм, соёлын байгууламжийг хүндэтгэн үзнэ¹²¹ гэж заасан.

7.4. ГҮЙЦЭТГЭЛИЙН 7-Р СТАНДАРТ

Эмнести Интернэшнл 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт өгсөн санал дүгнэлтдээ Гүйцэтгэлийн 7-р стандарт уугуул иргэдийн эрхийн тухай орчин үеийн хүний эрхийн хэм хэмжээг тусгаагүй, ялангуяа НҮБ-ын Уугуул иргэдийн эрх болон Чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшөөрөл олгох эрхийн тухай тунхаглалын үзэл санааг огт тусгаагүй байгаа талаар шүүмжилж байсан билээ.¹²² Хэдийгээр Гүйцэтгэлийн 7-р стандартын эх бичвэрт¹²³ зарим нэг дэвшил гарсан ч уугуул иргэдийн чөлөөтэй,

¹¹⁶ IFC, Performance Standard 5, Rev-0.1, *Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 74, para 10.

¹¹⁷ IFC, Performance Standard 5, Rev-0.1, *Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 77, para 21.

¹¹⁸ IFC, Performance Standard 5, Rev-0.1, *Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 78, para 23.

¹¹⁹ Paragraph 23 states that the client “will meet one or more of the following requirements, as applicable” - one of which relates to providing land-based compensation, rather than stating that the client should meet all applicable requirements. See: IFC, Performance Standard 5, Rev-0.1, *Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 78, para 23.

¹²⁰ IFC, Performance Standard 5, Rev-0.1, *Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 76, para 15.

¹²¹ IFC, Performance Standard 5, Rev-0.1, *Land Acquisition and Involuntary Resettlement*, 14 April 2010, p 77, para 19.

¹²² FPIC is a core requirement of the Declaration. The principle has been applied by the UN CERD Committee (See UN Committee on the Elimination of Racial Discrimination, “General Recommendation XXIII: Indigenous Peoples” (18 August 1997) A/52/18, annex V, Para 5); the UN Human Rights Committee, (UN Human Rights Committee, Engela Poma Poma 27/3/2009, Communication No. 1457/2006); and the Inter-American Court of Human Rights (See, eg, I/A HR Court, *Saramaka People v. Suriname*, Series C (No. 172) (2007)).

¹²³ For example, a recognition of the need to ensure that the assessment of land and natural resource use should be gender inclusive and specifically consider women’s role in the management and use of these resources, see, IFC, Performance Standard 7, Rev -01, *Indigenous Peoples*, 14 April 2020, p 90, para 16.

урьдчилан мэдээлэл авч зөвшөөрөл өгөх эрхийг бүрэн дүүрэн тусгаж чадаагүй байна.¹²⁴ Энэ талаар ОУСК “уугуул иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшөөрөл олгох эрхтэй холбоотой хэм хэмжээ, практикаас харахад ОУСК-ийн чөлөөтэй, урьдчилан мэдээллээр ханган зөвлөлдөх үйл явцтай зарчмын хувьд адилхан болох нь харагдсан”¹²⁵ гэж мэтгэж байгаа юм.

ЗӨВЛӨЛДӨХ ГЭДЭГ НЬ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ГЭДГЭЭС ЗАРЧМЫН ХУВЬД ЯЛГААТАЙ

Эмнести Интернэшнл ОУСК-ийн одоогийн мөрдөж байгаа уугуул иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангаж, зөвлөлдөх процесс нь уугуул иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшөөрөл өгөх эрхтэй зарчмын хувьд адил биш гэж үзэж байна. Учир нь уг процесс санал болгож байгаа төсөлд уугуул иргэд зөвшөөрөл олгосон эсхийг хэрхэн тодорхойлох талаар үйлчлүүлэгчдэд тодорхой заавар өгөөгүй байна. Харин түүний оронд “дэмжихээ илэрхийлсэн мэдэгдэл” авахыг шаардаж байгаа бөгөөд үүнд маш олон хүчин зүйлч, түүний дотор ганцаарчилсан тохиролцоо, ам бүл болон хэсэг бүлэг хүмүүстэй хийсэн тохиролцоо зэрэг хамааруулна.

ОУСК энэ асуудлыг шийдвэрлэхэд уугуул иргэдийг зайлшгүй татан оролцуулах шаардлагатай. Одоогийн байдлаар уугуул иргэдийн санал бодлыг сонсох талаар хангалттай хүчин чармайлт гаргаагүй байна. Ийм амин чухал асуудлаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө алдаа дутагдлаа засч залруулах зайлшгүй шаардлагатай.

УУГУУЛ ИРГЭДТЭЙ ЧӨЛӨӨТЭЙ, УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ, ЗӨВЛӨЛДӨХ ПРОЦЕСС НЬ ЗӨВШӨӨРӨЛ ЗАЙЛШГҮЙ АВАХ ШААРДЛАГААС ЗАЙЛСХИЙХЭД ХҮРГЭЖ БАЙНА

Гүйцэтгэлийн 7-р стандартад уугуул иргэдийг татан оролцуулах хоёр процессыг дурджээ. Эхнийх нь уугуул иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангаж, зөвлөлдөх процесс юм. Түүнээс гадна дараах тохиолдолд үйлчлүүлэгч компани төсөлд өртсөн нутгийн иргэдтэй “сайн санааны хэлэлцээ” хийх ёстой:

- i. Төсөл уламжлалт газар нутаг дээр хэрэгжих
- ii. Нүүлгэн шилжүүлэлт хийгдэхээр бол
- iii. Уугуул иргэдийн соёлын нөөцийг арилжааны зорилгоор ашиглахаар бол.¹²⁶

Дээрх хоёр процессын аль алинд уугуул иргэдийн “мэдээллээр хангагдсаны үндсэн дээрх оролцоо” гол шаардлага болон тавигджээ. Тухайлбал, уугуул иргэдийг үйлчлүүлэгч “уугуул иргэдтэй сайн санааны хэлэлцээ хийж, тэдний мэдээллээр

¹²⁴ For the time-being, IFC has chosen to retain the term FPIConsultation instead of FPIConsent. IFC has stated that a final decision on “consent” will be made by October 2010. See: IFC, *Progress Report on IFC’s Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, 14 April 2010, p 11, para 35.

¹²⁵ IFC, *Progress Report on IFC’s Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability, and Policy on Disclosure of Information: Review and Update Process*, 14 April 2010, p11, para 35. Amnesty International has not seen the review to which IFC refers, and so cannot assess the credibility of the study or its findings. However, Amnesty International notes that according to IFC as at 29 July 2009, only three projects had ever been required to document good faith negotiations with Indigenous peoples (IFC, *Report on the First Three Years of Application*, (2009), par 44.), which raises doubts about the extent to which IFC would have sufficient information to assess whether these processes could be considered equivalent to FPIC.

¹²⁶ Performance Standard 7, paragraph 11-15.

хангагдсаны үндсэн дээрх оролцоо болон хэлэлцээний үр дүнг баримтжуулснаас бусад тохиолдолд “ нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлж болохгүй гэж заасан. “Мэдээллээр хангагдсаны үндсэн дээрх оролцоо” гэдэг нь “үйлчлүүлэгч шийдвэр гаргах үйл явцдаа эрх ашгийг нь шууд хөндөж байгаа сөрөг үр дагаврыг бууруулах арга хэмжээ, хөгжлийн үр өгөөж, боломжийг хуваарилах, төслийн хэрэгжилт зэрэг асуудлаар нутгийн иргэдтэй зохион байгуулалттайгаар, тогтмол зөвлөлдөх үйл ажиллагаа”¹²⁷ гэж тодорхойлсон.

Гэвч зарчмын нэг асуудал байгаа нь эдгээр процессын аль нь ч төслийн үйл ажиллагаанд өртсөн нутгийн иргэдийн зөвшөөрлийг орхигдуулсан явдал юм. Үйлчлүүлэгч болон ОУСК-ийн зүгээс тухайн төсөлд нутгийн иргэдийн зөвшөөрлийг авах талаар тавигдах ямар ч тодорхой шаардлагыг дурдаагүй байна. Түүнээс гадна, зөвшөөрөл авах явдлыг төслийн янз бүрийн шатанд дахин давтагдах үйл явц гэж авч үзээгүй байна. Харин уугуул иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангаж, зөвлөлдөх болон сайн санааны хэлэлцээ хийх процессын аль аль нь нутгийн иргэдийн өргөн дэмжлэг байгаа эсэх, орон нутгийн иргэд “дэмжлэгээ илэрхийлсэн ” эсэх зэрэг шаардлагуудыг тусгасан.

Уг шаардлага нь Хүрээлэн буй орчин ба нийгмийн хяналтын журамд тусгагдсан хэдий ч Гүйцэтгэлийн 7-р стандартад орхигдсон байгаа нь ОУСК нутгийн иргэдийн өргөн дэмжлэг байгаа эсэхийг хэрхэн үнэлэх асуудал үүсгэж байгаа юм. Хүрээлэн буй орчин ба нийгмийн хяналтын журамд “төсөлтэй холбоотой дэмжлэг болон эсэргүүцлийн төвшин”¹²⁸-ий талаар нотолгоо гаргаж өгөхийг үйлчлүүлэгчдээс шаарддаг. Нутгийн иргэдийн дэмжлэг болон эсэргүүцлийг төслийг дэмжиж байгаа болон эсэргүүцэж байгаа талаар албан ёсоор болон албан бусаар гаргасан санал зэрэг “бодит үндэслэлийн”¹²⁹ дагуу үнэлнэ. Дэмжиж байгааг тодорхойлох хүчин зүйлст ганцаарчилсан ярилцлага, албан ёсны болон албан бус (уламжлалт) байгууламжуудыг татан оролцуулах, төсөлд өртсөн гэр бүлүүд болон бүлгүүдтэй байгуулсан тохиролцоо зэрэг багтана.¹³⁰ Ийнхүү нутгийн иргэдийг бодитойгоор татан оролцуулах явдал дутагдалтай, дэмжиж байгааг тодорхойлох хүчин зүйлс нь хэт ерөнхий зэрэг нь ОУСК болон түүний үйлчлүүлэгчдэд уугуул иргэдийн зөвшөөрлийг авахтай холбогдон үүсдэг асуудлуудаас зайлсхийх ихээхэн боломж олгожээ. Мөн “дэмжиж байгаа санал” олж авахын тулд үйлчлүүлэгчдэд нутгийн иргэдээс хэсэг бүлгээр нь саналыг цуглуусны дүнд тэдний өргөн дэмжлэгийг авсан гэдэг үнэлгээг өөрсдөө хийх боломж олгосон байна. Энэ нь нутгийн иргэдийн дунд зөрчил үүсгэх томоохон эрсдэл дагуулж болох юм.

Нөгөөтэйгүүр, ОУСК нутгийн иргэдийн өргөн дэмжлэгийг хэрхэн тодорхойлдог болоод дэмжлэгээ тийнхүү илэрхийлэх нь ямар үр дагавар авчрах талаар төслийн үр нөлөөнд өртсөн иргэдэд мэдээлэл хүргэх талаар ямар нэг үүрэг хүлээхгүй байгаа нь зохисгүй хэрэг юм.¹³¹ Нутгийн иргэдийн өргөн дэмжлэгийн талаар ОУСК-ийн хийсэн үнэлгээг баталгаажуулах бие даасан процесс буюу уугуул иргэдийн зүгээс дүгнэлт өгөх, баталгаажуулах өөр ямар нэг процесс алга байна. Энэ нь төслийн үйл ажиллагаанд өртсөн нутгийн иргэдийн хувьд шийдвэр гаргах үйл явцад хяналт тавих ямар ч боломж байхгүй бөгөөд гагцхүү ОУСК бүх зүйлийг хяналтандаа байлгана гэсэн хэрэг юм.

¹²⁷ Performance Standard 1, Paragraph 22.

¹²⁸ See, IFC, Environment & Social Review Procedure, Version 2.0, (31 July 2007), 33.

¹²⁹ See, IFC, Environment & Social Review Procedure, Version 2.0, (31 July 2007), 38.

¹³⁰ IFC, Environment & Social Review Procedure, Version 2.0, (31 July 2007), 38-39.

¹³¹ CAO, Review of IFC's Policy and Performance Standards on Social and Environmental Sustainability and Policy on Disclosure of Information, May 2010.

ОУСК САЙН САНААНЫ ХЭЛЭЛЦЭЭ БОЛОН НУТГИЙН ИРГЭДИЙН ӨРГӨН ДЭМЖЛЭГИЙГ ХЭРХЭН ҮНЭЛДЭГ ТУХАЙ

ОУСК нутгийн иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангасны үндсэн дээр зөвлөлдөх болон сайн санааны хэлэлцээ зэргээр дамжуулан нутгийн иргэдийн өргөн дэмжлэгийг авч чадсан эсэхийг хэрхэн үнэлж байгааг ОУСК-ийн олон тооны баримт бичиг, түүний дотор Тогтвортой байдлын бодлого, Хүрээлэн буй орчин ба нийгмийн хяналтын журмын хавсралт болон зөвлөх шинжтэй Удирдамж зэрэгтэй нарийвчлан танилцалгүйгээр тодорхойлох боломжгүй байна.

Гүйцэтгэлийн 7-р стандарт хэрхэн хэрэгждэгийг ойлгохыг хүсч байгаа хүн тэр мэдээллийг хаанаас олох вэ гэж хайх шаардлагагүй. Тэр мэдээлэл нь маш тодорхой бөгөөд ойлгомжтойгоор Гүйцэтгэлийн 7-р стандартад багтсан байх ёстой. Түүнээс гадна, сайн санааны хэлэлцээний тухай тодорхойлолт Гүйцэтгэлийн 7-р стандартын ишлэл хэсэгт биш харин уг стандартын гол эх бичвэрт тусгагдах ёстой.

УУГУУЛ ИРГЭДИЙН ЗӨВШӨӨРӨЛД ЮУ БАГТАХ ВЭ?

Уугул иргэд хэрхэн шийдвэр гаргадаг талаар болон төлөвлөгдсөн төсөлтэй холбоотой бүх мэдээллийг авсны үндсэн дээр нутгийн иргэд хэрхэн зөвшөөрөл өгөх талаар бодитой судалгаа явуулах шаардлагатай байна. ОУСК болон түүний үйлчлүүлэгчид нутгийн иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангагдсаны үндсэн дээр өгсөн зөвшөөрлийг авахын тулд илүү их цаг хугацаа, хөрөнгө зарцуулах ёстой.¹³²

ОУСК шийдвэр гаргах үйл явцыг нарийвчлан судалсан тохиолдолд нутгийн иргэдийн зөвшөөрлийг авалгүй үйл ажиллагаа явуулсан гэсэн аливаа гомдлыг итгэлтэйгээр шийдвэрлэх боломжтой болно. 2006 оны Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичигт бидний өгсөн санал дүгнэлтэд дурдаж байсанчлан ОУСК нутгийн иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангагдсаны үндсэн дээр өгсөн зөвшөөрлийг авах талаар хариуцлага хүлээх ёстой. Чухамдаа нутгийн иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангасны үндсэн дээр зөвлөлдөх процессын улмаас ОУСК шүүмжлэлд өртөж, хэсэг бүлэг хүмүүс хөгжлийн төслүүдийг эсэргүүцэхэд хүргэж байгаа юм.

¹³² Indigenous peoples' representatives to the ADB policy review provided the following formulation of FPIC requirements: "For the purposes of policy application, consent refers to a collective agreement by the affected Indigenous Peoples communities, through an independent and self-determined decision-making process undertaken with sufficient time and in accordance with their cultural traditions, customs and practices." Indigenous Peoples Submission to the ADB Safeguard Policy Review, December 4, 2008. Available at www.forestpeoples.org.

ХҮНИЙ ЭРХЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ЦАГ:

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИЙН ХҮНИЙ ЭРХИЙГ УХАМСАРТАЙГААР ХҮНДЭТГЭН САХИХ ҮҮРЭГ

Олон Улсын Санхүүгийн Корпораци нь Дэлхийн Банкны бүлгийн нэг хэсэг юм. ОУСК-ийн гол үүргийн нэг бол хөгжиж байгаа орнуудын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх явдал мөн. Хөгжиж байгаа орнууд хүний эрхийг үр дүнтэйгээр хамгаалах талаар ихээхэн сорилттой тулгардаг. ОУСК эрчим хүч, олборлолт, хөдөө аж ахуйн бизнес болон хүрээлэн буй орчныг сүйтгэж, хүний эрхийг ихээхэн зөрчдөг томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүд зэрэг бизнесийн үйл ажиллагааг дэмждэг. ОУСК-ийн санхүүжүүлдэг төслүүд ядуучуудын амьдардаг газар хэрэгжих нь олонтаа байдаг.

2009 онд ОУСК өөрийн үүрэг хариуцлага болон үйлчлүүлэгчдэдээ тавигдах шаардлагыг багтаасан Тогтвортой байдлын цар хүрээ хэмээх бодлогын баримт бичгээ хянан үзэх ажлыг эхлүүлсэн юм. Учир нь уг баримт бичиг ОУСК-ийн санхүүжүүлдэг үйл ажиллагаанаас үүдэх хүний эрхийн болоод нийгэм, хүрээлэн буй орчны үр нөлөөг зохих ёсоор тусгаагүй гэсэн шүүмжлэлд ихээхэн өртсөөр ирсэн.

Энэхүү илтгэлд Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн хувилбарын төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийсэн бөгөөд ОУСК уг баримт бичгийг шинэчлэн боловсруулах явцдаа хийсэн хүний эрхийн дүн шинжилгээнд үнэлэлт дүгнэлт өгсөн болно. Хэрэв ОУСК Тогтвортой байдлын цар хүрээ баримт бичгийн шинэчилсэн хувилбартаа олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зохих ёсоор тусгахгүй юм бол тус корпорацийн санхүүжүүлдэг үйл ажиллагаанаас үүдэн хүний эрхийн зөрчил гарсаар байх болно хэмээн Эмнести Интернэшнл үзэж байна.

www.amnesty.org
Index: IOR 80/004/2010
www.demanddignity.org



Эмнести Интернэшнл нь 150 гаруй улс орон, газар нутагт 3 сая хүнийг хамарсан хүний эрхийн хамгаалагчдын даян дэлхийн хөдөлгөөн юм.

“Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал” бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг энэ дэлхийн хүн бүрт бүрэн эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг, шашны үзлээс ангид - гишүүд болон олон нийтийн хандиваар санхүүждэг билээ.